

*МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН*  
**2024 ОНЫ ЭЭЛЖИТ БУС ЧУУЛГАН**

*2024 ОНЫ 08 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ*

**ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ**  
**БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН**

**ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС**

---

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

**БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
2024 оны 08 дугаар сарын 28-ны өдөр, Лхагва гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2-3
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	4-30

---

1.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	4-30
--	------

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит бус чуулганы  
Эдийн засгийн байнгын хорооны 08 дугаар сарын 28-ны өдөр  
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Эдийн засгийн байнгын хорооны дарга Р.Сэддорж ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 56.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 12 цаг 18 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

Томилолттой: Ж.Алдаржавхлан, М.Бадамсүрэн, П.Батчимэг;  
Эмнэлгийн чөлөөтэй: Ж.Ганбаатар, А.Ундраа;  
Тасалсан: Х.Баттулга, Лодойсамбуу, О.Цогтгэрэл.

**Нэг. “Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2023 оны гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлнэ/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх, мөн яамны Санхүү, бүртгэлийн хэлтсийн дарга Б.Баясгалан, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн, мөн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Б.Анхбаяр, Уул уурхайн бодлогын газрын дарга М.Мэндбаяр, Геологийн бодлогын газрын дарга Х.Санчигдорж, Төрийн захиргаа, удирдлагын газрын Санхүүгийн хэлтсийн дарга Б.Отгонцэцэг, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Төмөрхүү, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Ариунсанаа, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Т.Мөнгөнцэцэг, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Б.Анар, Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан, Үндэсний статистикийн хорооны дарга Б.Батдаваа, мөн хорооны Тамгын газрын дарга Б.Лхагва, Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Б.Төмөрхуяг, Монголбанкны ерөнхий эдийн засагч Д.Ган-Очир, Зам, тээврийн яамны Төрийн захиргаа, удирдлагын газрын дарга Б.Болор-Эрдэнэ, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Стратеги, хөгжлийн бодлого төлөвлөлтийн газрын дарга А.Даваажаргал, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Отгонбат, Сангийн яамны Төрийн сангийн газрын дарга Б.Цогбадрах, мөн газрын Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Баяр-Эрдэнэ, мэргэжилтэн Е.Ёндонсамбуу, мөн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга, Төрийн сангийн газрын Төлбөр, тооцооны хэлтсийн дарга В.Рэнцэнханд, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав, Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч Я.Самбууням, Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, мөн газрын аудитын менежер П.Чанцалдулам, Б.Долгорсүрэн, ахлах аудитор П.Амарсанаа, Э.Энхбаатар, Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал,

тэргүүлэх аудитор Д.Энхболд, мөн газрын аудитын менежер Ю.Энхтуяа, ахлах аудитор У.Оюунхүү, аудитор И.Балжинням нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

*Хуралдааныг 12 цаг 48 минутад Засгийн газрын хуралдаан дуустал түр завсарлуулж, 14 цаг 05 минутаас үргэлжлүүлэв.*

Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Б.Жавхлан, нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав нар танилцуулав.

Танилцуулга болон аудитын дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж, Л.Соронзонболд, М.Энхцэцэг, М.Мандхай, Р.Батболд, О.Батнайрамдал, Х.Ганхуяг нарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, мөн газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, Сангийн яамны Төрийн сангийн газрын дарга Б.Цогбадрах, мөн яамны Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Монголбанкны ерөнхий эдийн засагч Д.Ган-Очир нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан 15 цаг 00 минутаас хуралдааныг даргалав.

Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд, Б.Мөнхсоёл, М.Энхцэцэг, О.Батнайрамдал нар үг хэлэв.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 2 цаг 10 минут үргэлжилж, 25 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 68.0 хувийн ирцтэйгээр 15 цаг 45 минутад өндөрлөв.*

Тэмдэглэлтэй танилцсан:

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА

Р.СЭДДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**  
2024 оны 08 дугаар сарын 28-ны өдөр,  
Лхагва гараг Төрийн ордон “Үндсэн  
хууль” танхим 12 цаг 18 минут

**БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

**Р.Сэддорж:** Улсын Их Хурлын 2024 оны ээлжит бус чуулганы 2024 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн Эдийн засгийн байнгын хорооны хуралдаан эхэлж байна аа.

Ирц хэдэн хувьтай байна 56 хувьтай байна. Ингээд Байнгын хорооны эрхэм гишүүдийнхээ энэ өдрийн амгаланг айлтгая. Хуралдаанд оролцож байгаа гишүүдээ танилцуулъя.

Хуралдаанд Сэддорж, Алтанишагай, Батболд, Батсүмбэрэл, Батшугар, Бямбасүрэн, Жаргалан, Лувсанжамц, Мөнхсоёл, Уянгахишиг, Цэнгүүн, Энхтүвшин, Энхцэцэг нарын гишүүд хүрэлцэн ирсэн байна аа.

Шалтгаантай гишүүд шалтгаанаа хэлээгүй байна. Ингээд Байнгын хорооны ирцийг танилцуулж дууслаа. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж Байнгын хорооны ирц 56 хувьтай бүрдсэн тул Эдийн засгийн байнгын хорооны 2024 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье ээ.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл Засгийн газрын санхүүгийн нэгдсэн нэгтгэсэн тайлан болон Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл, энэ төслийг Засгийн газар 2024 оны 8 сарын 12-ны

өдөр өргөн мэдүүлсэн, 2 дахь хэлэлцүүлэг, санал дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлнэ ээ.

Хэлэлцэх асуудалтай холбоотой өөр саналтай гишүүд байна уу? Лувсанжамц гишүүн.

**Г.Лувсанжамц:** Энэ өдрийн мэндийг хүргэе. Нэгэнт нөгөө хүмүүс нөгөө тайлбар ч гэх юм уу танилцуулах хүмүүс нь байхгүй болохлоор хэдүүлээ одоо цаашидаа Эдийн засгийн байнгын хороо яаж ажиллах вэ гэсэн тэр тал дээр хоорондоо санал солилцоод танилцуулга хийх хүмүүс нь орж иртэл нь тийм зүйл яриад сууж байвал яах вэ гэж бодож байна. Нэгэнт энэ юу байгаа юм чинь завшааныг ашиглаад айн? Тэрийгээ тэгээд хэзээ ярьдаг юм бол?

**Р.Сэддорж:** Хэлэлцэх асуудалтай холбоотой санал байна уу? Хэлэлцэх асуудал дээр хурал бол эхэлчихсэн санал байхгүй байна. Ингээд хэлэлцэх асуудал өнөөдөр Засгийн газрын хуралдаантай өдөр. Ээлжит бус чуулганыг уг нь бол өнөөдөр дуусгах ёстой байсан боловч 30-ны өдөр дуусгахаар сонгож хуралдаж байгаа. Тэгээд өнөөдөр Засгийн газрын хуралдааны өдөр, 3 дахь өдөр. Тэгээд хуралдаан давхцаж байгаа. Яг хариуцсан сайд нар байхгүй байгаа учраас энэ дотроо яригдах аудитын дүгнэлт байгаа. Аудитын дүгнэлтээ сонсож байя аа. Ажлын хэсгийг оруулъя ажлын хэсгээ оруулъя. Засгийн хурал дуусаагүй, сайдууд хуралдаа орж ирэхгүй байгаа учраас 1 цаг 40 минут хүртэл хуралдааныг завсарлуулж байна аа.

**ЗАВСАРЛАГА**

**Р.Сэддорж:** Хэлэлцүүлгийг үргэлжлүүлбье. Хурал үргэлжилж байна. Хэлэлцэх асуудал.

Нэг. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан болон Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн 2 дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье ээ.

Төсвийн гүйцэтгэлийн талаарх Засгийн газрын илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Болдын Жавхлан танилцуулна аа. Сайдын микрофоныг нээе.

Баярлалаа.

**Б.Жавхлан:** Эрхэм Эдийн засгийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг хуулийн хугацаанд нэгтгэн гаргаж Төрийн аудитын төв байгууллагаар аудит хийлгэн Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит бус чуулганы 8 дугаар сарын 27-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлэгт танилцуулсан билээ.

Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 2023 онд 3 их наяд төгрөг, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 22.5 их наяд төгрөг, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 2.2 их наяд төгрөгийн алдагдалтай төлөвлөгдсөнөөс 785 тэрбум төгрөгийн ашигтай гарсан ба сүүлийн жилүүдэд дараалан төсвийн алдагдлыг үе шаттайгаар буурууллаа.

Монгол Улсын нэгдсэн төсвийн алдагдлыг үе шаттайгаар буурууллаа төсвийн гүйцэтгэл Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланг тус Байнгын хороонд харьяалагдан Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хороо, Монгол Улсын сайд, 20 минутын хот, үндэсний хороо, Аж үйлдвэр, эрдэс

баялгийн сайд, Зам, тээврийн сайд, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд, Эрчим хүчний сайд, Үндэсний статистикийн хороо, Санхүүгийн зохицуулах хорооны нийт 652 байгууллагын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг нэгтгэн гаргалаа. Нэгдсэн төсвийн гүйцэтгэлээр тус Байнгын хорооны төсвийн ерөнхийлөн захирагчдын нийт зарлага болон цэвэр зээлийн дүн 2.1 их наяд төгрөгийн гүйцэтгэл гарч үүнээс урсгал зардалд 435 тэрбум төгрөг, хөрөнгийн зардалд 1.7 их наяд төгрөгийг зарцуулсан байна аа.

Нийт зарлага болон цэвэр зээлийн дүнгийн 21.9 хувь буюу 468.6 тэрбум төгрөгийг Зам тээврийн сайд, 17.7 хувь буюу 379.4 тэрбум төгрөгийг Хот байгуулалт, барилга орон сууцжуулалтын сайд, 19.6 хувь буюу 420.5 тэрбум төгрөгийг Соёл спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд, 14.1 хувь буюу 302 тэрбум төгрөгийг Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засгийн хөгжлийн сайд, 12 хувь буюу 254.8 тэрбум төгрөгийг Эрчим хүчний сайд, 11.4 хувь буюу 244.7 тэрбум төгрөгийг Монгол Улсын сайд, 20 минутын хот, Үндэсний хороо, 1.8 хувь буюу 38.9 тэрбум төгрөгийг Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд, 1 хувь буюу 20.1 тэрбум төгрөгийг Үндэсний статистикийн хороо, 0.4 хувь буюу 8.9 тэрбум төгрөгийг Санхүү хүүгийн зохицуулах хороо, 0.2 хувь буюу 3.7 тэрбум төгрөгийг Монгол Улсын сайд, Боомтын сэргэлт, Үндэсний хорооны зарлага тус тус эзэлж байна аа.

Улсын төсвөөс 2.1 их наяд төгрөгийн санхүүжилтийг олгосон бол төсөвт байгууллагын өөрийн орлогоор 40.3 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлсэн байна аа.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Та бүхэн 2023 оны төсвийн гүйцэтгэлийн үр дүнгийн тоон

үзүүлэлтүүд болон бусад холбогдох тайлан танилцуулга, аудитын дүгнэлттэй танилцуулж, Төсвийн тухай хуулийн дагуу Монгол Улсын 2023 онд төсвийн гүйцэтгэлийн батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж өгнө үү.

*Анхаарал тавьсанд баярлалаа.*

*Жавхлан сайдад баярлалаа.*

**Р.Сэддорж:** Нэгдсэн төсөв, төсвийн гүйцэтгэл болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор Дэлэгийн Загджав танилцуулна аа. Ерөнхий аудиторын микрофоныг нээе.

**Д.Загджав:** Та бүхэндээ энэ өдрийн мэнд хүргэе ээ.

Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Төрийн аудитын байгууллага аудитын тухай хуульд заасан бүрэн эрх төсвийн тухай хуулийн дагуу төсвийн ерөнхийлөн захирагчдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Тус байнгын хороонд харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл болон улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр дүнд хийсэн аудитын талаар товч танилцуулъя.

Эдийн засаг, хөгжлийн сайд эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан 5 байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэснээс 3 байгууллагад дүгнэлт гарган 2 байгууллагыг түүвэрт хамруулсан. Аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд өөрчлөлтгүй 22

байгууллагад өөрчлөлтгүй, 1 байгууллагад хязгаарлагдмал дүгнэлт өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар 230.6 сая төгрөгийн 14 зөрчил илэрснээс 0.2 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож 84.2 сая төгрөгийн 5 албан шаардлага хүргүүлж 146.2 сая төгрөгийн 8 зөвлөмж өгсөн. Нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой 19 тэрбум 396.3 сая төгрөгийн 7 алдааг аудитын явцад залруулсан. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудлаар нийт 192.1 сая төгрөгийн 4 зөрчил илэрч 152.1 сая төгрөгийн 2 албан шаардлагад 40 сая төгрөгийн 2 зөвлөмж хүргүүлсэн. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 55 тэрбум 634.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 43 турбум 193.8 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 2 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Төсөл арга хэмжээний санхүүжилт 54 хувийн гүйцэтгэлтэй байна. Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны санхүүгийн нэгдсэн тайланд 37 байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэснээс 27 байгууллагад дүгнэлт гарган 10 байгууллагыг аудитын дүгнэлтэд хамруулсан. Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгдсэн тайланд хязгаарлалттай харьяа 22 байгууллагад өөрчлөлтгүй, 5 байгууллагад хязгаартай дүгнэлт өгсөн. Санхүүгийн тайлангийн аудитаар 151.6 тэрбум төгрөгийн зөрчил илэрснээс 0.2 тэрбум төгрөгийн зөрчилд 23 төлбөрийн акт тогтоож, 147.5 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгах 37 албан шаардлага хүргүүлж 2.7 тэрбум төгрөгийн зөрчилд 44 зөвлөмж өгч 1.2 тэрбум төгрөгийн зөрчилд хариуцлага тооцуулах 3 албан шаардлага хүргүүлсэн.

Нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой 15.4 тэрбум төгрөгийн 39 алдаа илэрснээс аудитын явцад 15.4 тэрбум төгрөгийн алдааг залруулж нэг зөвлөмж өгсөн. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудлаар нийт 188.8 тэрбум төгрөгийн

26 төсөл илэрснээс 188.3 тэрбум төгрөгийн 14 албан шаардлага 0.5 тэрбум төгрөгийн 12 зүйлд хүргүүлсэн. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 24 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 11.9 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 6 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Төсөл арга хэмжээний санхүүжилтийн гүйцэтгэл 100 хувьтай байна. Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны санхүүгийн нэгдсэн тайлан харьяа 34 байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэснээс 29 байгууллагад дүгнэлт гаргаж, 5 байгууллагыг түүвэрт хамруулсан.

Аудитор төсвийн эрхлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хязгаарлалттай 29 байгууллагад өөрчлөлтгүй, 5 байгууллагад хязгаарлалттай дүгнэлт, 1 байгууллагад сөрөг дүгнэлт өгсөн байна аа.

Санхүүгийн тайлангийн аудитаар 35.9 тэрбум төгрөгийн зөрчил илэрснээс 0.4 тэрбум төгрөгийн зөрчилд 31 төлбөрийн акт тогтоож 30.9 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгах 57 албан шаардлага хүргүүлж 4.6 тэрбум төгрөгийн зөрчилд 106 зөвлөмж өгч хариуцлага тооцуулах нэг албан шаардлага хүргүүлсэн. Нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой нийт 544.2 тэрбум төгрөгийн 52 алдаа илэрснээс 544.1 тэрбум төгрөгийн 47 алдааг аудитын явцад залруулж 0.1 тэрбум төгрөгийн 5 алдааг давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө. Санхүүгийн тайлангийн явцад шалгасан нийцлийн асуудлаар нийт 260.4 тэрбум төгрөгийн 48 зөрчил илэрснээс нэг төлбөрийн акт тогтоож 13.3 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгах 11 албан шаардлага хүргүүлж 209.1 тэрбум төгрөгийн зөрчилд 38 тэрбум төгрөгийн зөрчилд хариуцлага тооцуулах 3 албан шаардлага хүргүүлсэн. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 1 их наяд 577 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 408.8 тэрбум төгрөгийн санхүүжих

дүнтэй, 120 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Төсөл арга хэмжээний санхүүжилт 92 хувьтай хэрэгжсэн байна. СЗХ-ны даргын төсвийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар өөрчлөлтэй дүгнэлт өгсөн.

Аудитаар илэрсэн нийт 1 сая төгрөгийн 2 зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлж нягтлан бодох бүртгэл тайлантай холбоотой 62.2 сая төгрөгийн нэг алдааг залруулсан.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 0.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 0.5 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй нэг төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж бүрэн хэрэгжсэн байна. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны санхүүгийн нэгдсэн тайлан, 24 байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэснээс 17 байгууллагад дүгнэлт гаргаж, 7 байгууллагыг түүвэрт хамруулсан.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгдсэн тайланд хязгаарлалттай харьяа 11 байгууллагад өөрчлөлтгүй, 6 байгууллага хязгаарлалттай дүгнэлт өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар 110.3 тэрбум төгрөгийн 145 зөрчил илэрснээс 1.8 тэрбум төгрөгийн зөрчилд 11 төлбөрийн акт тогтоож 65.7 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгаж 63 албан шаардлага хүргүүлж, 28.6 тэрбум төгрөгийн 64 зөвлөмж өгч 4.1 тэрбум төгрөгийн зөрчилд хариуцлага тооцуулах, 4 албан шаардлага хүргүүлж хууль хяналтын байгууллагад 10.1 тэрбум төгрөгийн 8 асуудлыг шилжүүлсэн. Нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой 1 их наяд 116.8 тэрбум төгрөгийн 65 алдаа илэрснээс аудитын явцад 1 их наяд 117 тэрбум төгрөгийн 69 алдааг залруулж 16.1 тэрбум төгрөгийн



16 алдааг давтан гаргахгүй байх арилгах зөвлөмж өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитор шалгасан нийцлийн асуудлаар нийт 303.5 тэрбум төгрөгийн 47 зөрчил илэрснээс 288.1 тэрбум төгрөгийн зөрчилд 12 албан шаардлага хүргүүлж, 15.4 тэрбум төгрөг төгрөгийн зөрчилд 35 зөвлөмж өгсөн.

ҮСХ-ны даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 23 байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэснээс 9 байгууллагад дүгнэлт гаргаж 14 санхүүгийн тайланг түүвэрт хамруулсан. Аудитаар нийт 75.6 сая төгрөгийн 23 зөрчил илэрснээс 4.9 сая төгрөгийн зөрчилд 6 төлбөрийн акт тогтоож 2.7 сая төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага хүргүүлж 68 сая төгрөгийн зөрчилд 12 зөвлөмж өгч хариуцлага тооцуулах 1 албан шаардлага хүргүүлсэн.

Аудитаар нягтлан бодох бүртгэл тайлантай холбоотой нийт 776.2 сая төгрөгийн 18 алдаа илэрснийг аудитын явцад залруулсан. Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан төсвийн гүйцэтгэлд харьяа 73 байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэснээс 49 байгууллага дүгнэлт гаргаж, 24 байгууллагыг түүвэрт хамруулсан. Аудитор төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан хязгаарлалттай харьяа 42 байгууллагад өөрчлөлтгүй 7 байгууллага хязгаарлалттай дүгнэлт өгсөн.

Санхүүгийн тайлангийн түвшинд 5 тэрбум төгрөгийн зөрчил илэрснээс 17.4 сая төгрөгийн 19 төлбөрийн акт тогтоож 2.7 тэрбум төгрөгийн 55 албан шаардлага хүргүүлж 2.3 тэрбум төгрөгийн 69 зөвлөмж өгсөн. Нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой 24.9 тэрбум төгрөгийн 67 алдаа илэрснийг аудитын явцад залруулсан. Санхүүгийн тайлангийн аудитаар

шалгасан нийцлийн асуудлаар нийт 6 тэрбум төгрөгийн зөрчил илэрч 4.6 тэрбум төгрөгийн зөрчилд 14 албан шаардлага 1.4 тэрбум төгрөгийн зөрчилд 24 зөвлөмж хүргүүлсэн. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 10.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 7.5 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 3 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Төсөл арга хэмжээний санхүүжилт 93 хувийн гүйцэтгэлтэй байна аа. Шадар сайд бөгөөд Боомтын сэргэлтийн үндэсний хорооны даргын 2023 оны санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт өгсөн. Санхүүгийн тайлангийн аудитор тэр нийт 1.5 тэрбум төгрөгийн зөрчил илэрсэнд 2 зөвлөмж өгч, нягтлан бодох бүртгэл тайлантай холбоотой 2.6 тэрбум төгрөгийн нэг алдааг залруулж санхүүгийн тайлангийн аудит шалгасан нийцлийн асуудлаар нэг албан шаардлага хүргүүлсэн. Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны санхүүгийн нэгдсэн тайланд харьяа 33 байгууллагын санхүүгийн тайлан нэгдсэнээс 30 байгууллагад дүгнэлт гаргаж 3 байгууллага шүүхэд хамруулсан.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хязгаарлалттай харьяа 21 байгууллага өөрчлөлтгүй, 8 байгууллагад хязгаарлалттай, 1 байгууллагад сөрөг дүгнэлт өгсөн. Санхүүгийн тайлангийн аудитаар 105.8 тэрбум төгрөгийн зөрчил илэрснээс 0.2 тэрбум төгрөгийн 53 төлбөрийн акт тогтоож 89.9 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгаж, 85 албан шаардлага хүргүүлж, 15.2 тэрбум төгрөгийн зөрчилд 123 зөвлөмж өгч хариуцлага тооцох 4 албан шаардлага хүргүүлж, хууль хяналтын байгууллагад 0.5 тэрбум төгрөгийн нэг асуудлыг шилжүүлсэн байна. Нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой 302.4 тэрбум төгрөгийн 81 алдаа илэрснийг аудитын явцад залруулсан.

Санхүүгийн тайлангийн аудитад шалгасан нийцлийн асуудлаар нийт 47.6

тэрбум төгрөгийн 55 төсөл илэрснээс 44.5 тэрбум төгрөг төгрөгийн зөрчил 29 албан шаардлага, 3.1 тэрбум төгрөгийн зөрчилд 26 зөвлөмж хүргүүлсэн. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 482.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 169 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 42 төсөл арга хэмжээг төлөвлөсөн. Төсөл арга хэмжээний санхүүжилтийн гүйцэтгэл 96 хувьтай хийгдсэн байна.

Аудитын дүгнэлтээс нэн тэргүүнд анхаарах асуудлыг тоймлон танилцуулъя.

Тус Байнгын хороо хороо, Аудитын дүгнэлтэд үндэслэн дараах асуудлуудад анхаарал хандуулахыг зөвлөж байна.

1.Чөлөөт бүсүүдийн үйл ажиллагаандаа мөрдөх дүрэм журам чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж батлуулах, барих, шилжүүлэх төрлийн концессын гэрээгээр хэрэгжүүлж дууссан хатуу хучилттай авто зам, зогсоол, дэд бүтэц, станцын өргөтгөлийн ажлын холбогдох баримт материалын бүрдэл хөрөнгө нэг бүрийн үнийн задаргаа хөрөнгө шилжүүлэн авах. Төрийн болон орон нутгийн өмчит ААН-ийг тогтоож балансаас баланст шилжүүлэх.

3.Төсвийн ерөнхийлөн захирагчдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад хэрэгжүүлэхэд дотоод хяналт хангалтгүй. Төрийн аудитын байгууллагаас хүргүүлсэн шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангуулах үр дүнтэй арга хэмжээ авч хэрэг үзүүлэх.

4.Төсөв хөрөнгийг зохистой удирддаггүйгээс авлага, өр төлбөр үүсгэсэн, тооцоо нийлж баталгаажуулаагүй, хугацаа хэтэрсэн болон олон жилийн насжилттай эзэн холбогдогчгүй болж найдваргүй болох эрсдэлтэй авлагыг барагдуулах.

5.Худалдан авах ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулах.

6.Ашиглах боломжгүй болсон авто зам, автомашин, барилга байгууламжийг холбогдох байгууллагад хандаж шийдвэрлүүлэх өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг сайжруулах.

Дараагийн дугаарт Засгийн газрын шийдвэрээр төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүд нийгмийн шинж чанартай төсөл арга хэмжээг санхүүжүүлж байгаа нь төсвийн нэгдсэн бодлогын зарчмыг алдагдуулж байгаа зөрчлийг арилгах.

Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн засаглах эрх зүйн орчныг олон улсын жишигт нийцүүлэх, үйл ажиллагааны хараат бус ил тод байдлыг хангах талаар Улсын Их Хурлаас гаргасан шийдвэрүүдийг хэрэгжүүлж ажиллах.

Танилцуулж дууслаа.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Р.Сэддорж:** Ерөнхий аудитор Загджав гуайд баярлалаа.

Ажлын хэсгийг танилцуулъя.

Сангийн сайд Болдын Жавхлан. Сайд сая Төсвийн байнгын хороон дээр гялс уншчихаад ороод ирье гэсэн асуултад хариулна аа. Санхүүгийн зохицуулах хорооны дарга Дэмбэрэлдашийн Баярсайхан, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Сандагийн Магнайсүрэн, Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Сандагдоржийн Батболд, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга Сүхбаатарын Төмөрхүү, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Нансалын Тавинбэх. Бас нэг хүн орлож байгаа. Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Идэшийн Батхүү, Үндэсний

статистикийн хорооны Тамгын газрын дарга Бямбасүрэнгийн Лхагва, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн захиргаа, удирдлагын газрын Санхүүгийн хэлтсийн дарга Болдын Отгонцэцэг, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Болдбаатарын Анхбаяр, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Уул уурхай бодлогын газрын дарга Мэлсчогийн Мэндбаяр, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Геологийн бодлогын газрын дарга Хүрэлбаатарын Санчигдорж, ҮСХ-ны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Буураагийн Төмөрхуяг, ЗТЯ-ны Захиргаа, удирдлагын газрын дарга, Баасанжавын Болор-Эрдэнэ, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Санхүү хөрөнгө оруулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Цэгэнойдовын Ариунсанаа, ЭХЯ-ны Санхүү, бүртгэлийн хэлтсийн дарга Баярсайханы Баясгалан, Соёл, спорт, аялал жуулчлал залуучуудын яамны Стратеги хөгжлийн бодлогын төлөвлөлтийн газрын дарга Адьяасүрэнгийн Даваажаргал, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Жигмэдсамбуугийн Отгонбат, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Бат-Ирээдүйн Анар, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга, Ерөнхий санхүүч Төмөрбаатарын Мөнгөнцэцэг, Сангийн яамны Төрийн сангийн газрын дарга Бэлтрэгийн Цогбадрах, Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Ганболдын Золбоо, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт хөрөнгө оруулалтын газрын дарга Жамьяншаравын Дэлгэржаргал, Сангийн яамны Санхүүгийн удирдлагын хэлтсийн дарга Солонгын Тулга, Сангийн яамны Төрийн сангийн газрын төлбөр тооцооны хэлтсийн дарга Ванчингийн Рэнцэнханд, Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга Лувсандоржийн Гантогтох, Сангийн яамны Төрийн

сангийн газрын Санхүүжилт тайлан бүртгэлийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Баясгалангийн Баяр-Эрдэнэ, Сангийн яамны Төрийн сангийн газрын санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн мэргэжилтэн Ембүүгийн Ёндонсамбуу нар хүрэлцэн ирсэн байна.

ҮСХ-ны дарга Батдаваа хуралд ирсэн байна. Аудитаас Монгол Улсын Ерөнхий аудитор Загджав, Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч Самбуунямбуу, Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Наранчимэг, Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Энхболд, Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын аудитын менежер Энхтуяа, Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын ахлах аудитор Оюунхүү, Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын аудитор Идэрийн Балжинням, Санхүү-нийцлийн аудитын газрын аудитын менежер Чанцалдулам, Санхүү-нийцлийн Аудитын газрын аудитын менежер Долгорсүрэн, Санхүү нийцлийн аудитын газрын ахлах аудитор Амарсанаа, Санхүү-нийцлийн аудитын газрын ахлах аудитор Энхбаатар нар хүрэлцэн ирсэн байна аа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74.4.2-т зааснаар Байнгын хороод нэгдсэн төсвийн гүйцэтгэл болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулах үед гишүүд төсвийн гүйцэтгэл санхүүгийн нэгдсэн тайлантай холбогдуулан зөвхөн Сангийн сайд болон Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдаас асуулт асуух дэгтэй гэдгийг урьдчилан сануулъя.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлантай холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгье.

Энхцэгг гшшүүнээр тасаллаа. Би Байнгын хорооны гшшүүний хувьд асуултаа асуугаад ингээд явъя.

Нэгдүгээрт нь Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд нийт орлогын дүн 23 их наяд төгрөгөөр төлөвлөгдсөн боловч 2023 оны энэ төсвийн гүйцэтгэлээр 24.3 их наяд төгрөгөөр биелсэн. 105 их наяд төгрөгөөр буюу 6 хувиар давуулан орлогоо төвлөрүүлж биелүүлсэн холбогдох байгууллагын хүмүүс, Сангийн яам, татвар, бусад байгууллагын хүмүүст баяр хүргэж талархал илэрхийлье ээ.

Энэ дотор нэгдсэн төсвийн нийт зарлага 24.2 их наядар төлөвлөгдсөн байснаас санхүүгийн тайланд тусгагдсан гүйцэтгэлийн дүнгээс харахад 22.5 их наяд төгрөг зарцуулсан байгаа. Үүний зөрүү 1.7 их наяд төгрөгөөр дутуу зарцуулсан. Дутуу зарцуулсан ямар шалтгаан нөхцөлтэй холбоотой байсан бэ?

Жишээлбэл манай салбарын СЗХ-ны төсөв 12.2 тэрбум төгрөгөөр төлөвлөгдөөд гүйцэтгэл нь 8.9 тэрбум төгрөг болсон байгаа. Үндэсний статистикийн хороон дээр 20.9 тэрбум төгрөгөөр, Зам, тээврийн хөгжлийн сайд төлөвлөснөөс мөн л дутуу гүйцэтгэлтэй байна аа. Дутуу гүйцэтгэлтэй байгаа нь тооцооллын алдаа байсан уу эсвэл хөрөнгө оруулалт нь оройтоод хугацаандаа амжаагүй байсан уу? Эсвэл хэрэгжилт дээр ямар нэгэн алдаа гарсан уу гэдгийг асууя.

Хоёрт нь санхүүгийн нэгдсэн тайланд хийсэн аудитын дүгнэлтээр Эдийн засгийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээний төсвийн ерөнхийлөн захирагчдаас 2023 оны гүйцэтгэлээр төсвийн хязгаарлалттай гэсэн дүгнэлттэй гарсан байгууллага албан тушаалтан байгаа юу? Үүнтэй холбоотойгоор хариуцлага тооцсон зүйл байна уу? Санал хүргүүлсэн үү? Хязгаарлалттай гэж дүгнэгдэх шалтгаан

нөхцөл бий ю? Байсан уу? Цаашид хэрхэн засаж сайжруулахаар төлөвлөж байгаа талаар асууя. Хариулах хүмүүс хэн байна?

Хариулах хүмүүс дугаартай микрофон дээр. 4 номерын микрофон. Нэр албан тушаалаараа хэлээд.

**Д.Баярсайхан:** Санхүүгийн зохицуулах хороо Баярсайхан. Гишүүний асуултад хариулъя. 2023 онд Санхүүгийн зохицуулах хороонн дээр 2.7 тэрбум төгрөгийн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж гээд. Энэ дээр хэмнэлт гарсан байгаа. Гол учир шалтгаан нь Монгол Улс мөнгө угаах терроризмтой, санхүүжилттэй тэмцэх үнэлгээг 2023 онд хийлгэхээр төлөвлөж байсан. Өөрөөр хэлбэл олон улсын мөнгө угаалт терроризмтой санхүүжилттэй тэмцэх ФАТФ-ын жилийн үнэлгээг Монгол Улс 2023 онд хийлгэнэ гээд энэтэй холбоотой нэлээн өндөр дүнтэй санхүүжилт тавигдсан байсан. Энэ үнэлгээг ФАТФ-ын зүгээс 2027 он болгож хойшлуулсан. Энэнтэй холбоотой дээрээс нь мэдээж бас төрийн хэмнэлтийн хуультай холбоотой тодорхой хэмнэлтүүд гараад яг 2023 оны гүйцэтгэл дээр бол 2.7 тэрбум төгрөг буюу төсөвт нь харьцуулаад үзэх юм бол 39.3 хувийн ийм хэмнэлт гарсан байгаа.

**Р.Сэддорж:** 5 номерын микрофон.

**Б.Лхагва:** Эдийн засгийн байнгын хорооны даргын асуултад хариулъя. Үндэсний статистикийн хорооны 2023 оны төсвийн гүйцэтгэл дээр 806 орчим сая төгрөгийн төсвийн хэмнэлт гарсан байгаа. Энэ 2 бүлэгт хуваагдаж байгаа. Хэмнэлт гарсан шалтгаан 1 дүгээрт цалингийн нийт хэмнэлт дээр нийтдээ 293 сая орчим төгрөгийн хэмнэлт гарсан. Энэний гол шалтгаан бол орон тоо ноднин 7 сар цалин нэмэх хүртэл ерөнхийдөө төрийн албан хаагчдын орон тоо дутуу явж байгаад энэн дээр холбоотой цалингийн хэмнэлт гарсан байгаа.

Хоёрдугаар хэмнэлт болохоороо манай төсвийн бусдаар гүйцэтгэх ажил үйлчилгээ буюу ҮСХ-ноос явуулсан нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа, өрхөд суурилсан судалгаа, амьдрах орчны аюулгүй байдлын судалгаа дээр нийтдээ 453 орчим сая төгрөгийн хэмнэлт гарсан байгаа. Хэмнэлтийн гол шалтгаан бол I дүгээрт судалгааны явах техник машин хангамжийн үйлчилгээ, бензин шатахууны үйлчилгээ худалдан авах ажиллагаа дээр хэмнэлт гарсан.

Хоёрдугаарт Эдийн засгийн байнгын хорооны гишүүдэд танилцуулсан. Бид Жи Пи Эс мониторинг систем гарснаар нөгөө хяналт илүү сайжирч хэмнэлт гарсан. Энэтэй холбоотой шалтгаанууд дээр хэмнэлт гарсан байгаа.

**Р.Сэддорж:** Нэг номер.

**Б.Болор-Эрдэнэ:** Зам, тээврийн хөгжлийн яам Болор-Эрдэнэ. Энэ бол манай дээр гарсан хэмнэлт гэх юм уу энэ бол нөгөө ИНЕГ-ын Иргэний нисэхийн үндэсний төв дээр гол нь зурлагууд байсан. 163 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт зардлууд төлөвлөсөн боловч Орос Украины асуудлаас болоод Иргэний нисэхийн үндэсний төвийн олох орлого огцом буурсан учраас Иргэний нисэхийн үндэсний үндэсний төв ИНЕГ маань 134 тэрбумын зардал болгож зардлаа 20 орчим тэрбумаар бууруулсан.

Энэтэй холбоотой хөрөнгө оруулалтын зарим төслүүдийг хойш нь тавьсан эндээс гарсан зүйлсүүд байгаа. Бусад яамны ЗТХЯ-ны хүрээнд бол 99.8, 97.7 хувийн биелэлтүүдтэй бүх хөрөнгө оруулалт урсгал зардлууд явсан.

**Р.Сэддорж:** Аудит 2 номер.

**Ц.Наранчимэг:** Байнгын хорооны даргын асуултад хариулъя.

Үндэсний аудитын газар Наранчимэг байна аа. Эдийн засгийн

байнгын хороонд харьяалагддаг төсвийн ерөнхийлөн захирагчдаас Барилга, хот байгуулалтын сайд, Зам, тээврийн хөгжлийн сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрлэлийн сайд, Шадар сайд, Эрчим хүчний сайд санхүүгийн тайлангийн аудитаар хязгаарлалттай санал дүгнэлтийг авсан. Төрийн аудитын тухай хуульд нэмэлт өөрчлөлт орсноор хязгаарлалттай санал, дүгнэлт авсан байгууллагуудад хариуцлага тооцдог асуудал бол хариуцлага тооцохоо больсон. Сөрөг дүгнэлт авбал хариуцлага тооцно. Аудит хийхээс татгалзвал ажлаас халах хүртэлх албан шаардлагыг Монгол Улсын Ерөнхий аудитор өгдөг. Ийм хуулийн зохицуулалт. Шинэ зохицуулалт бол хэрэгжиж байгаа. Зүгээр тус Байнгын хороонд харьяалагдах нийт төсвийн ерөнхийлөн захирагчдаас дүгнэлтээс бусад асуудлаар 16 албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлагыг томилдог эрх бүхий албан тушаалтанд нь хүргүүлсэн байгаа. Бид санхүүгийн тайлангийн аудитын завсрын аудитыг дараа буюу өмнөх өгсөн зөвлөмж, албан шаардлагаар тогтоосон төлбөрийн актын хэрэгжилтийг 9 дүгээр сараас эхэлж аудит ордог ийм зохицуулалттай. Тэгэхээр энэ аудитаар өмнөх аудитаар өгсөн шийдвэрийн хэрэгжилтээ дүгнэж дараа жилийн төсвийн гүйцэтгэл дээр тайлагнана.

**Р.Сэддорж:** Тодорхой дүгнэлтүүдээ өгчихсөн юм байна тийм үү? Тэгээд одоо нэр дурдсан Санхүү зохицуулах хороо, Үндэсний статистикийн хороо, Зам, тээврийн яам эд нар бол гомдол санал байхгүй юм байна тэ? Тэр нэг газраас болж энэнээс болж дутуу зарцуулсан гэсэн юм бол байхгүй юм байна тийм үү? Сайн байна. Ойлголоо.

Лхагвасүрэнгийн Соронзонболд гишүүн.

**Р.Сэддорж:** Эдийн засаг хөгжлийн яамны төсвийн гүйцэтгэл дээр ТЭЗҮ гэдэг өрөн дээр 7.5 тэрбум төгрөгийн хэмнэлт гарсан юм байна аа. Энэ ямар төслийн

ТЭЗҮ хийх ёстой байсан ажил хийгдээгүй вэ? Энэ ажил нь 2025 онд орж байгаа юм уу гэдэг асуулт байна, нэгдүгээрт.

Хоёрдугаарт энэ нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн аудит дээрээс энэ Төрийн банктэй холбоотой ноогдол ашигийг Үндэсний Аудитын газраас төвлөрүүлэх ёстойг нь төвлөрүүлээгүй гэж үзсэн юм байна л даа. Төрийн банкны тайлбар нь болохоор төрийн захиргааны төв байгууллагад хамаарах хувьд нь тааруулж ноогдол ашиг хуулийг шилжүүлсэн гэж тайлбар өгсөн юм байна. Энэ дээр ер нь бол ямар байдлаар шийдэж байгаа вэ гэж асуулт байна.

**Р.Сэддорж:** Соронзонболд гишүүний асуултад хариулъя. Сангийн яам. Хэдэн номер вэ? 2 номер хариулъя.

**Ц.Наранчимэг:** Соронзонболд гишүүний асуултад хариулъя. Үндэсний аудитын газар Наранчимэг 2 дахь асуултад нь хариулъя.

Ноогдол ашигтай холбоотой Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 341 дүгээр тогтоолоор төрийн өмчид ноогдол ашиг төвлөрүүлэх байгууллагуудын ноогдол ашигийг тогтоож өгсөн байгаа. Энүүгээр бол Төрийн банканд 48 тэрбум төгрөгийн ноогдол ашигийг төвлөрүүлнэ гэсэн ийм тогтоол байгаа. Аудитаар төсвийн гүйцэтгэлд аудит хийхэд 27.4 тэрбум төгрөгийн ноогдол ашигийн дутуу төвлөрүүлэлттэй байгаа. Энийг бид аудит хийгээд энэ Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын ноогдол ашиг төвлөрүүлэх тогтоолоо Төрийн банкныг хувьцаат компани болсонтой холбогдуулж энийгээ өөрчлөх шаардлагатай юм байна гэдэг. Ийм асуудал дээр гаргасан шийдэл гаргасан учраас бид энэ дээр төлбөрийн акт тогтоогоогүй. Харин энэ банкнуудын энэ хувьчлал, хувьцаат компани болж байгаа биржид нээлттэй хувьцаа гаргаж байгаа энэ тохиолдолд ноогдол ашигийг хэрхэн төлж төвлөрүүлэх тал дээр бодлого

хэрэгтэй юм байна шийдэл хэрэгтэй юм байна гэдгийг аудитаар дүгнэж гаргасан. Тийм учраас төлбөрийн акт тогтоогоод.

**Р.Сэддорж:** Өөр хариулах хүн байна уу? Соронзонболд гишүүнд тодруулга байна уу? Энэ чинь Эдийн засгийн хөгжлийн яамны 2023 оны юугаараа бол Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг хөгжлийн яамтай холбоотой л асуудал асуусан шүү дээ. Тэгэхээр энэ асуудалд болохоор мөн адилхан Эдийн засгийн хөгжлийн яам хариулах байлгүй дээ. Эхний асуулт нь Эдийн засгийн хөгжлийн яамнаас байгаа хүмүүс хариулаарай. Сангийн сайдыг дуудаарай.

Асуултад хариулах хүн байхгүй байна уу? 3 номер.

**Б.Ганзориг:** Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Ганзориг Соронзонболд гишүүний асуултад хариулъя. Ер нь Эдийн засаг хөгжлийн сайдын багц дээр жил болгон бид нар бүх том дүнгээр нь ТЭЗҮ зураг төсвийн мөнгийг суулгаад явж байгаа. Тэгээд Эдийн засаг хөгжлийн сайд тушаалаараа уг нь энэ ТЭЗҮ-ийн ажлуудыг задалж зарцуулалт хийдэг байгаа. Тэгээд тэр саяын энэ аудитын дүгнэлтэд дээр гарсан хэмнэлт бол тухайн тушаалаар Эдийн засаг хөгжлийн сайд ямар нэгэн хуваарилалт хийгээгүй байгаа гэсэн үг. Харин энэ жилийн 2024 оны төсөв дээр бол 40 тэрбум төгрөг бид нар бөөн дүнгээр ингээд суулгасан байгаа. Сая тодотголоор бас зайлиггүй шаардлагатай нэмэгдүүлэх үүднээс бид нар мөн 40 тэрбум төгрөгийг ингээд нэмээд энэ жилийн тодотгол ингээд явж байгаа. Тэгэхээр үндсэндээ бол Эдийн засаг, хөгжлийн сайдын тушаал тухайн санхүүжилтийг задалж байгаа. Тэгэхээр бусад салбарын яамдууд бүх төсвийн ерөнхийлөн захирагч нар бол хүсэлтээ Эдийн засаг хөгжлийн яаманд хүргүүлдэг байгаа юм аа.

**Р.Сэддорж:** Баярлалаа. Ренчиндоржийн Батболд гишүүн асуулт асууя.

**Р.Батболд:** Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Нэгдсэн төсвийн гүйцэтгэл ингээд 2 хоногийн дотор үзээд танилцаад ямар нэгэн дүгнэлтээ гаргаад яв гэдэг энэ цаг хугацааны хувьд маш их богино хугацаа орж ирж байна аа. Зүгээр иргэдийн дунд нэг яриа байдаг шүү дээ. Энэ сонгуулийн жил болохоор л сонгуулийн төсөв баталчихлаа гээд байдаг. Тэгээд энэ төсвөөр дамжуулаад эрх баригчид маань маш их хэмжээний мөнгийг гаргаад сонгуульд зараад байна гээд байдаг. Тэгээд энийгээ одоо энэ яг үнэндээ энэ 450 хуудас материал дотор хаана ямар тоо хийгээд хаячихсаныг нь харах боломж үнэндээ алга байна. Тэгээд засаг олонх болсон энэ 3 намынхан маань ямар ч байсан энийг олонхоороо шийдээд явах нь явах байх.

Зүгээр ерөнхий нэг 2 гуравхан асуулт асуучихъя. Аудитын байгууллага маань ингээд дүгнэлтээ гаргаад ингээд зөвлөмж хүргүүлээд байдаг юм байна аа. Энэний гүйцэтгэлийг нь өөрсдөө хянаж гэдэг юм уу, дүгнэдэг юм уу, эс үгүй бол хариу авдаг юм уу? Энэ ямархуу түвшинд явдаг юм бэ? Энэ нэг 5 жил, 10 жил энэ төсөл арга хэмжээнд хэрэгжээд яваад байдаг. Төсвөөс санхүүжиж байгаа дүн нь бүүр зарим нь бүүр 7 дахин нэмэгдчихсэн явж байгаа энэ асуудлууд чинь мэдээж жил болгон давтаад л орж ирээд байдаг байлгүй дээ. Тэгэхээр энэ тал дээр Үндэсний Аудитын газар маань юу гэж боддог юм? Энийг харьяа яамдуудаас асуучихмаар байгаа юм. Та бүхний харьяанд байгаа төсөл арга хэмжээнүүд хэрэгжиж байгаа одоо энэ хугацаандаа ашиглалтад ордоггүй төсвүүд нь нэмэгдээд байдаг ийм ажлууд хэчнээн хэмжээнийх байдаг юм бэ? Одоо үлдэгдэл нь ер нь ямархуу байдаг юм бол гэж нэг асуучихмаар байна.

Хоёрдугаар асуулт нь энэ нөгөө дампуурсан банкнуудад байсан энэ

сангийн хөрөнгүүд ер нь ямархуу хэмжээнд эргэн төлөлттэй байдаг юм бол. Ер нь хэчнээн хэмжээний алдагдал гарсан байдаг юм. Энэ талаар нэг мэдээлэл байвал өгөөч? Энэ юутай холбож асуух гээд байна гэхээр одоо энэ 2023 оны төсвийн тодотгол дээр болохоор нөгөө баялгийн сангийн хөрөнгөөс 499, 500 орчим тэрбум төгрөгийг санхүү, хөрөнгө оруулалтын төсөлд байршуулна гэхчхэн байж байгаа. Тэгэхээр энэ байршуулах газрууд нь тодорхой болсон юм уу, дахиад баахан нөгөө эрсдэлтэй банкнууддаа байршуулчих юм уу гэдэг тал дээр хариулт авмаар байна.

**Р.Сэддорж:** Хариулт 2 номерыг өгье.

**Ц.Наранчимэг:** Гишүүний асуултад хариулъя. Үндэсний аудитын газар Наранчимэг байна аа. Төрийн аудитын байгууллагаас аудит хийгээд төлбөрийн акт тогтоодог, албан шаардлага хүргүүлнэ. Төлбөрийн акт, албан шаардлага 2 бол заавал хэрэгжих ийм хуулийн зохицуулалттай. Зөвлөмжийг хүргүүлдэг. Төсвийн тухай хуулийн 2023 оны 7 дугаар сард орсон өөрчлөлтөөр аудитын байгууллагаас аудит хийсэн тайланг хүлээж аваад 30 хоногийн дотор алдаа зөрчлийг хэрхэн засаж сайжруулах талаар арга хэмжээгээ төлөвлөж ирүүлэх хуультай. 30 хоногийн дотор төлөвлөгөөгөө ирүүлээгүй бол хариуцлага тооцох ийм хуулийн зохицуулалттай болсон байгаа. Бид аудит хийгээд, зөвлөмж өгөөд, тухайн жилдээ зөвлөмжийг хэрэгжүүлээгүй бол албан шаардлага хүргүүлдэг. Албан шаардлагыг хэрэгжүүлээгүй бол хариуцлага тооцох албан шаардлагыг тухайн хариуцсан албан тушаалтны хариуцлага тооцох, нэр заасан ийм албан шаардлагыг хүргүүлдэг ийм хуулийн зохицуулалттай байгаа. Аудитын байгууллагаас өгсөн зөвлөмж, албан шаардлага, төлбөрийн актыг бид жил бүр өөрсдөө давтан аудит хийж хянадаг. Энэ дээр одоо

тусгайлан аудитын тайлан гаргаж бүх төсөв захирагч нарт энэ акт албан шаардлагын хэрэгжилтийн талаар бас дүгнэлтээ хүргүүлдэг байгаа. Аудитын байгууллагаас удаа дараа өгч байгаа нэг зөвлөмж, Байнгын хороодод өгч байгаа нэг зөвлөмж юу байна вэ гэхээр зэрэг хариуцсан Байнгын хороод нь төсвийн ерөнхийлөн захирагчдынхаа энэ аудит хийсэн тайлангуудыг мөн аудитын байгууллагаас өгсөн зөвлөмж, тогтоосон төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилтийг хэлэлцдэг байвал энэ бол бас зүй зохистой. Аудитын үр дүн гарах юм гэж ингэж үзэж энэ асуудлыг бол Байнгын хороо болон Улсын Их Хуралд жил бүр бид тайлангаараа зөвлөж байгаа. Монгол Улсын Ерөнхий аудитор зөвлөх эрхтэй учраас энэ асуудлыг зөвлөж байгаа гэсэн ийм хариулт байна аа.

**Р.Сэддорж:** Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яам 2 хариулна шүү дээ. Сангийн яам 3 номер. Эдийн засгийн хөгжлийн яамнаас байна уу?

**Б.Ганзориг:** Гишүүний асуултад хариулъя.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар яг таны хэлдгээр ингээд 10-аас дээш жил хэрэгжээд явж байгаа хэд хэдэн төслүүд байгаа. Тэгээд энэ төслүүдийн гацсан шалтгаан нь анх төсөвт суухдаа зураг төсөвгүй юм уу эсвэл Улсын Их Хурлын хэлэлцүүлгийн шатад нэмэгдсэн тийм төслүүд байдаг. Тэгээд яах вэ гарсных нь дараа зураг төсөв нь төсөв дээр батлагдсаны дараа зураг төсөв нь хийгдээд ингээд явах үед төсөвт өртөг нь нэмэгдэх ийм тохиолдлууд гардаг. Тэгээд энэ жилийн хууль дээр бид нар энэ 2024 оны төсвийн хууль дээр анх удаа төсвийн 2 дугаар хавсралт дээр тухайн төслийнх нь анхны төсөвт өртөг гэдэг баганыг оруулсан байгаа. Яагаад гэхээр энэ төсөв маань анх хэдэн төгрөгөөр батлагдаад 2024 онд хэд болчихсон байгаа юм бэ гэдгийг олон нийтэд нээлттэй ил тод харуулах үүднээс бид нар оруулсан. Тэгээд нэлээн

хэд хэдэн төслүүд одоо яг 2024 оны жишээн дээр 261 төсөлд бид нар Үндэсний аудитын газрын дүгнэлттэйгээр төсөвт нэмж тусгасан байгаа. Тэгэхдээ энэ Үндэсний аудитын газрын ямар эрх зүйн баримт дээр үндэслэж аудит хийсэн бэ гэхээр Их Хурлын 88 дугаар тогтоолоор энэ төсөвт өртөг нэмэгдэж байгаа ажлууд дээр Барилгын хөгжлийн төвийн гаргасан экспертизийн дүгнэлт дээр үндэслээд аудит хийгддэг чиглэл өгчихсөний дагуу хийсэн. Тэгээд энэ дагуу бид нар санхүүжилтүүдийг ингээд тусгаад явж байгаа.

Тэгэхээр энэ оны хууль дээрээс эхлээд энэ анхны төсөвт өртөг, одоо тусгагдсан байгаа төсөвт өртгийг ингээд ил тод нээлттэй харуулдаг болоод явсан байгаа юм аа.

**Р.Сэддорж:** Батболд гишүүн тодруулга байгаа юу. Батболд гишүүний микрофон. Нөгөө баялгийн сангийн 500 орчим тэрбумыг хаана байршуулах гээд байгаа талаар. Тэгээд яг юунд оруулах гэж байгаа вэ гэдэг. Батболд гишүүний асуултад хариулъя. 3 номер.

**С.Тулга:** Сангийн яамны хэлтсийн дарга Тулгаа гишүүний асуултад хариулъя. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 10.3-д заасны дагуу хуримтлалын сангийн орлого нь Монгол банкны дансан дээр байршидаг. Тэгээд санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулахдаа Засгийн газар төв банк 2-ыг гэрээ байгуулсны үндсэн дээр санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулж байгаа. 2024 онд хуримтлалын сангийн орлогоор олсон 499.5 тэрбум төгрөгийг ипотекийн зээлийн санхүүжилт гаргасан. Ипотекийн сая зээлийн санхүүжилт гаргахад Төв банк, Засгийн газар 2 гэрээ байгуулаад тэгээд бодлогын хүүгээс багагүй хувиар жилийн өгөөж өгөхөөр ийм гэрээ байгуулсан байгаа. Ипотек нь өөрөө Монгол Улсын санхүүгийн хэрэгсэл дунд ер нь хамгийн эрсдэл багатай



санхүүгийн хэрэгсэл гэж тооцогдож байгаа.

**Р.Сэддорж:** Гончигдоржийн Уянгахишиг гишүүн асуулт асууна. Олон Байнгын хорооны хурал давхцаж байгаа учраас Батбаярын Жаргалан гишүүн хурлыг удирдаж явуулна.

**Г.Уянгахишиг:** Өдрийн мэнд хүргэе ээ. Гурван асуулт байна.

Нэгдүгээрт, Үндэсний аудитын газрын тайлангийн 5.2.18-д тайлант онд ашиглалтад гараагүй 2014-өөс 2021 онуудад гэрээ байгуулсан 2024-өөс 2032 онуудад үндсэн төлбөрөө төлж эхлэх 617.7 тэрбум төгрөгийн 10 гадаад зээлийн үлдэгдэл 15.3 тэрбум төгрөгийн хүүгийн зардал төлсөн байна аа. Тэгээд гадаад төслийн зээлийн ашиглалтыг сайжруулахгүй бол цаашид гадаад зээлийн үйлчилгээний хураамжийн зардлыг нэмэгдүүлэхээр байна гэсэн байна. Энэ дээр нэг тодруулаад асуучихмаар зүйл нь энэ дээр дурдагдсан Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр 2019 оноос хэрэгжиж эхэлсэн Улаанбаатар хотын ногоон байгууламжийн 95 сая амдолларын төсөл 01 хувийн гүйцэтгэлтэй, хүүгийн зардал 1.7 тэрбум төгрөг төлсөн байна гэж байгаа юм. Тэгэхээр энэ төслийн саатаад байгаа шалтгаан нь юу вэ гэх юм бол уг нь Улаанбаатар хотод чинь ногоон байгууламж маш их хэрэгтэй л байгаад баймаар нэгдүгээр асуулт.

Хоёрдугаар асуулт болохоороо 3 дугаар бүлэг дээр. 3.4 дээр улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж хүлээн авсан зарим барилга угсралтын ажлын инженерийн шугам сүлжээний холболт дэд бүтцийн асуудлыг иж бүрэн байдлаар төлөвлөж хэрэгжүүлээгүйгээс хүлээн авсан барилга байгууламж ашиглалтгүй мөн зарим байгууламжийн ажил хугацаандаа ашиглалтад ороогүйгээс бэлтгэсэн тавилга тоног төхөөрөмж нь ашиглалтгүй хадгалагдаж байна гээд тухайлбал гээд дурдаж нэлээн олон

төслүүдийг дурдсан байна. Тэгэхээр энэ дээр асуулт нь буцаагаад төсөв дээр маш олон аймаг сум орон нутагт барилга байгууламж төслүүд төсөв дээр зардлаар бууж ирдэг, сууж ирдэг. Тэгээд буцаагаад гүйцэтгэл нь өөрөө тэр төсвөө зарцуулаад барилга байгууламжаа барьчихаад тэр нь өөрөө ашигладаггүй байгаад байдаг шалтгаан нь юу юм оо? Энэний хяналтыг яаж сайжруулах юм бол? Энэ дээр ер нь ямар арга хэмжээ авч энэ чинь 2023 оны гүйцэтгэлийн тайлан байгаа шүү дээ.

Тэгэхээр 2024 онд нэмж авсан арга хэмжээ нь юу байдаг юм болоо гэдэг ийм 2 дахь асуулт байна. 3 дахь асуулт нь болохоор нийгмийн даатгалын сантай холбоотой нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөг 2.3 хувиар давуулж бүрдүүлсэн гэсэн байгаа юм. Тэгэхээр энэ ер нь орлогын төлөвлөгөөнд нь нийгмийн даатгалын санд байгаа мөнгөний өгөөжийг тооцсон байдаг юм болов уу. Өөрөөр хэлэх юм бол арилжааны банканд эсвэл Засгийн газрын бондод байршуулах боломжууд нь байгаа. Тэгэхээр энэ дээр өгөөжийн хувь тавьдаг болов уу энэ нь орлого бүрдүүлэлтэд ордог уу гэдэг асуулт байна. Мөн энэ дээр Капитал банкны эрх хүлээн авагчаас авах 68.2 тэрбум, Чингис хаан банканд байршиж буй.

**Б.Жаргалан:** Уянгаа гишүүний нэг минутыг өгье. Уянгахишиг гишүүний микрофоныг.

**Г.Уянгахишиг:** 94.9 тэрбум төгрөгийн сангийн хөрөнгө эрсдэлтэй байна аа гэсэн байгаа юм. Тэгэхээр одоо энэ маань нийт мөнгөнийхөө хувьд зуун тавин тэрбум болчихож байна шүү дээ. Тэгэхээр 160 хэдэн тэрбум. Тэгэхээр энэ мөнгөний өөрийнх нь өгөөжийн алдагдлыг тооцож бодож байгаа болов уу. Одоо ингээд жилийн юу гэдэг юм нэг 15 хувийн хүүгээр бодох юм бол энэ жилд 24 тэрбумын алдагдал үүсээд яваад байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ тал дээр тайлбар авмаар байна аа.

**Б.Жаргалан:** Гадаад зээлийн ашиглалттай холбоотой асуултад Сангийн яам хариулъя. Сангийн яамнаас хэн хариулах вэ? 3 дугаар микрофоныг өгье.

**Б.Ганзориг:** Сангийн яамны хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Ганзориг гишүүний асуултад хариулъя. Саяын гишүүний ярьдаг тэр нөгөө Улаанбаатарт хэрэгжиж байгаа ногоон орон сууцын төсөл маань яг өөрөө өмнөх Азийн хөнжлийн банкны энэ гэр хорооллын хөрөнгө оруулалтыг дэмжих төслийн дэд төвүүд гээд энэ Монголд Улаанбаатар хотод нийтдээ 6 дэд төв барьж байгаа. Тэгээд энэ Баянхошуу, Сэлбэ дэд төв дээр барих ажлын газар чөлөөлөлтийн асуудал ингээд нийслэлийн төсвөөсөө шийдэгдэхгүйгээр удсан. Тэгээд үүнтэй холбоотойгоор тухайн барилгын газар чөлөөлөлтийн асуудлаас болоод энэ төсөл маань ингээд жоохон хэрэгжилт нь удаашраад явж байгаа. Тэгэхдээ сая өнгөрсөн онд тендерүүд нь зарлагдаад одоогоор Баянхошуу болон энэ Сэлбэ дэд төв дээрээ хэд хэдэн ногоон орон сууцынхаа ажлыг ингээд эхлүүлээд явж байгаа. Энэ хэд хэдэн төслийнхөө хүрээнд хамт шийдэгдээд явж байгаа юмнууд байгаад байгаа юм. Тийм. Баярлалаа.

**Б.Жаргалан:** Энэ Улаанбаатар хотоос хүн байгаа юм уу нийслэлтэй холбоотой бас зүйл яригдаж байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ Байнгын хороон дээр ийм чухал асуудал яригдаж байхад хүмүүс маань бүгдээрээ байвал сайн байх юм. Нэг номер хариулах юм байна тийм үү? Нэг номерын микрофоныг.

**Д.Энхболд:** Уянгахыг гишүүний асуултад хариулъя.

Үндэсний аудитын газар Энхболд 2 дахь асуултад Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ хэрэгжиж дууссан боловч ашиглалтгүй байна гэдэг дээр Үндэсний аудитын газраас Монгол Улсын Шадар

сайд Эдийн засгийн хөгжлийн сайдад зөвлөмж өгсөн. Энэ дээр аудитаар бол хэд хэдэн газар дээр хөрөнгө оруулалтын арга хэмжээ дууссан гэж үзэж байгаа боловч гаднах шугам сүлжээ эх үүсвэрийг нь бүрэн төлөөгүй, төсөвлөлтийн шаардлага хангаагүй ийм арга хэмжээг хэрэгжүүлж хүлээлгэж өгсөн байсан. Ийм ажлууд нь хөрөнгө оруулалтын үр өгөөжгүй байдлыг бий болгож байгаа учраас төсөвлөлтийн шаардлага хангасан төсөл арга хэмжээг Төсвийн тухай хуульд баталж хэрэгжүүлдэг байя гэдэг ийм зөвлөмжийг өгсөн. Энэ дээр бол 3 төсөл арга хэмжээ байна. Архангай аймгийн аймгийн Ихтамир суманд байгуулагдсан цэцэрлэгийг гадна шугам сүлжээгүйгээр барьж ашиглалтад оруулсан. Мөн Барилга, хот байгуулалтын сайдын Баян-Өлгий аймаг дахь 3.2 тэрбумын төсөвт өртөгтэй 1900 айлын орон сууцын асуудал гаднах шугам сүлжээгүй баригдсан байсан. Мөн Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын 3 дугаар цэцэрлэгийн асуудлууд байсан. Эдгээрийг нэгтгээд бид нар Эдийн засгийн хөгжлийн сайдад хөрөнгө оруулалтын үр өгөөжийг дээшлүүлэх талд оролцуулж өгсөн.

**Б.Жаргалан:** Нийгмийн даатгалын сантай холбоотой асуулт нь бол нөгөө манай Эдийн засгийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд багтдаггүй байгаа. Тэгэхээр энэ асуултаа бол Нийгмийн бодлогын байнгын хорооноос асууж болно. Дараагийн гишүүн Мөнхчулууны Энхцэцэг гишүүний микрофоныг өгье.

**С.Энхцэцэг:** Сайн байцаана уу? Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Би 4 асуултыг асууя.

Нэгдүгээр асуулт нь сүүлийн үед дотоодын компаниуд хийж чаддаг ажлуудаа гаднын компаниудад алдах боллоо гэсэн гомдол их гардаг болсон. Тэгэхээр улсын төсвийн хөрөнгө оруулалт худалдан авалтын хэдэн ширхэг гэрэг гаднын компанитай байгуулсан байна вэ? Үүний төсөвт өртөг нь хэд байна вэ? Энэ

нь одоо нийт худалдан авалтын хэдэн хувь мөнгөн дүнгээрээ болон тоогоороо болж байгаа вэ? Үүнээс гадна мөн ТӨК-удын худалдан авалтын хэдэн гэрээг гаднын компанитай байгуулсан. Мөн төсөвт өртгөөрөө ямар дүнтэй байгаа энэ нь хэдэн хувь байгаа вэ гэдгийг хэлж өгөөч ээ.

Хоёрдугаарт нь чанартай холбоотой асуудал.

Сүүлийн үед маш олон барилга байгууламж чанаргүй баригдаж байгаа. Улсын төсвөөр барилга баригддаг. 1-ээс 2 жилийн дараа навсайсан байдалтай болж засвар хийх асуудал яригддаг. Тэгэхээр энэ төслийн чанарын хариуцлагын асуудлыг ямархуу байдлаар хэрэгжүүлж явж байгаа вэ?

Гуравдугаар асуудал болохоор 3-аас дээш жил хэрэгжиж байгаа төслүүд яг одоогоор хэдэн ширхэг байгаа вэ? Тэдгээр төсвийн тэдгээр төслүүдийн анхны төсөв нь хэдэн хувиар нэмэгдчихсэн явж байна. Тендерийн хуулиар бол энэ төслүүдийн гэрээг цуцлах ёстой. Гэвч ихэнх төслүүд нь хугацааг нь төсвийг нь ингээд хязгааргүй сунгаад яваад байдаг. Тэгэхээр ингэж улсыг хохироогоод ч юм уу явах боломж байгаад байдаг асуудал байдаг энэ дээр хариулт өгөөч гэж байгаа юм. Дөрөвдүгээр асуулт болохоор эрчим хүчний сайдаас асуумаар байна. Салбарын хөгжлийг тодорхойлоход бол стандарт маш чухал. Тэгэхээр салбарт хэрэгжиж байгаа бүхий л төслүүдээс тодорхой хэмжээний төсвийг авч үлдэж нормчлолын сан гээд үүсгэгддэг. Энэ нормчлолын сангүй салбарын стандартыг боловсруулах сайжруулахад зарцуулагдаад явж байх ёстой. Тэгэхээр энэ сангийн зарцуулалт эрчим хүчний салбар дээр хэр явагдаж байгаа вэ? 2022 онд хэр хэмжээний мөнгө энэ нормчлолын сан дээр хуримтлагдсан. Тэгээд 2023 оны хувьд хэдэн ширхэг стандартыг сайжруулах, шинээр бий болгоход энэ хөрөнгийг зарцуулсан бэ гэж асууя. Баярлалаа.

**Б.Жаргалан:** Улсын төсөв болон орон нутгийн өмчийн худалдан авалтын хувь хэмжээтэй холбоотой асуултад Сангийн яам хариулъя. 3 номерын микрофоныг өгье.

**Б.Ганзориг:** Гишүүний асуултад хариулъя. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа бүх ажлууд дээр та бүхэн мэдэж байгаа байх. Нөгөө Тендерийн тухай хуулиараа гадаадын этгээд оролцох эрхгүй гээд. Ганцхан Дорнод аймгийн дулааны станцын 50 мегабайтын төсөл дээр л Хятад компани ажиллаж байгаа. Бусад бүх төсөл дээр манай Монгол компаниуд ажиллаж байгаа. Харин гаднын зээл тусламжийн төслөөр өнгөрсөн онд бол нийтдээ 140 төсөл хэрэгжсэн.

Тэрний 140 төсөл дээр бол та бүхэн мэдэж байгаа. Ингээд том том бүтээн байгуулалтын ажлууд нь дандаа тухайн санхүүжүүлэгч байгууллагынхаа дүрэм журмаар явдаг учраас олон улсын нээлттэй тендер зарлагддаг. Тэгээд энэн дээр Хятад компаниуд мөн юу гэдэг юм Солонгосын талтай байгуулсан хэлэлцээрийнхээ дагуу бол зээлийнхээ ерөнхий хэлэлцээр дээр угаасаа 60 хувиас доошгүй хувийг нь тухайн түнш байгууллагын орноос эх үүсвэр дээрээс худалдан авалт хийнэ гэсэн заалттай. Мөн гүйцэтгэх компанийг нь тухайн улсын компаниудыг шалгаруулна гэсэн заалттай байдаг. Тэгэхээр Польш, БНСУ, Хятад зэрэг орнуудын хэрэгжиж байгаа төслүүд дээр дандаа гаднын гүйцэтгэх компаниудтай явж байгаа. Азийн хөгжлийн банкн дээр ч гэсэн ер нь бол дандаа олон улсын нээлттэй тендер зарлагддаг учраас орж ирж байгаа. Улсын төсөв дээр ганцхан ажил энэ жил жишээ нь 1300 ажил хэрэгжиж байгаа. Тэгээд та сая асуулаа 3 жилээс дээших хугацаатай хэрэгжиж байгаа гэдэг ажлууд бол нэг 50 орчим хувьтай байгаа. Яагаад гэхээр өнгөрсөн онд ер нь нэлээн их шинэ хөрөнгө оруулалтууд эхэлсэн. Тэгээд энэ жилийн хувьд бол бид нар зөвхөн энэ

шинээр эхэлсэн ажлуудаа дуусгах ийм гол бодлого бариад ажиллаж байгаа.

**Б.Жаргалан:** Сангийн яамнаас нэгмөсөн улсын төсвийн хөрөнгө оруулалтын чанартай холбоотой хяналтын талаар хариулт хэлэх үү? 3 номерын микрофоныг.

**Б.Ганзориг:** Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа бүх объектууд дээр ерөөсөө улсын хэмжээнд гуравхан мэргэжлийн байгууллага захиалагчийн хяналт хийж байгаа. Барилгын хөгжлийн төв, Эрчим хүчний хөгжлийн төв, Зам тээврийн хөгжлийн төвөөс хяналт хийж байгаа. Тэгэхээр тухайн салбарынх нь бас барилгын чанарыг бол энэ 3 байгууллагын төлөөллүүд хариулах нь зөв байх.

Ямар ч байсан Сангийн яам бол захиалагчийн хийсэн хяналт дээр үндэслээд төсвийн ерөнхийлөн захирагчаас ирсэн санхүүжилт материал дээр үндэслээд санхүүжилтийг олгодог байгаа.

**Б.Жаргалан:** Эрчим хүчний хөгжлийн төв байгаа юм байна тийм үү? Сая чанартай холбоотой асуудал дээр хариулт өгөх боломж байна уу? Эсвэл Барилгын яам хариулах гэж байна уу? 3 номерын микрофон.

**С.Төмөрхүү:** Хот байгуулалт, барилга орон сууцжуулалтын яамны ТНБД-ын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Төмөрхүү хариулж байна. Улсын хэмжээнд баригдаж байгаа барилга угсралтын ажлууд барилгын ажлууд дээр Барилгын хөгжлийн төв захиалагчийн хяналтыг хийж ажиллаж байгаа. Тэгэхдээ Барилгын хөгжлийн төв бол Улаанбаатар хотод байрладаг экспертүүдээ явуулж хяналтаа хийлгэдэг. Энд гараад байгаа нэг хүндрэл бол хуучин Барилгын яамны харьяа байсан Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар харьяалал нь өөрчлөгдөж шилжсэнээс болоод орон нутагт байгаа

газрын харилцаа, Барилга, хот байгуулалтын хэлтсүүд өөр салбарт харьяалагддаг болсон. Энэнтэй холбоотойгоор орон нутагт ажиллаж байгаа барилгын улсын байцаагч нарын харьяаллын асуудал шийдэгдээгүй. Ийм хүндрэл 2024 онд гараад байгаа. Энэ асуудлыг цаашид шийдэж орон нутагт барилгын улсын байцаагч нарын харьяаллын тодорхой болгож ажиллуулж, барилгын захиалагчийн хяналтыг чанартай хийх боломжтой болно гэж ингэж үзэж байгаа.

**Б.Жаргалан:** Төмөрхүү даргад баярлалаа.

Гурваас дээш жил хэрэгжиж байгаа хэдэн төсөл байгаа вэ гэсэн асуулыг Энхцэцэг гишүүн асуусан. Аудитын тайланд бол 10-аас дээш хэрэгжиж байгаа 16 асуулт байгааг 16 төсөл байгаа гэсэн нэг зүйл уншсан байгаа. Тэгэхээр энэ асуултад Сангийн яамны төлөөлөл хариулъя. Сангийн яамныхан маань ер нь энэ дугаартай микрофон дээр сууж байвал яасан юм. 3 номер.

**Б.Ганзориг:** Би гишүүний асуусан асуултад яг төслийнх нь тоогоор хариулъя. 2010 онд эхэлсэн нэг төсөл байна 2011 онд эхэлсэн 3 төсөл байна. 2012 онд эхэлсэн 2 төсөл байна, 2013 онд эхэлсэн мөн 2 төсөл, 2014 онд эхэлсэн 4 төсөл, 2015 онд эхэлсэн 2 төсөл, 2016, 2017 онд эхэлсэн нэг нэг төсөл 2018 онд эхэлсэн 42 төсөл, 2019 онд эхэлсэн 142 төсөл, 2020 онд эхэлсэн 257 төсөл байна аа. Тэгэхээр үлдсэн төслүүд нь бүгдээрээ 2020 оноос хойш эхэлсэн. Тэгэхээр үндсэндээ түрүүний миний хэлдэг хэрэгжээд явж байгаа төслүүдийн ингээд 50 орчим хувь нь 3 жилээс дээш хугацаанд хэрэгжсэн. Өнгөрсөн 2023 онд нийтдээ 1143 төсөл улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжээд явсан байна аа.

**Б.Жаргалан:** Энхцэцэг гишүүн Эрчим хүчний сайдаас асуулт асуусан. Сая Тавинбэх дарга бол бол Төсвийн

байнгын хорооноос дуудагдаад явсан байгаа. Орных нь хүн байна уу? 4 дүгээр микрофоныг өгчих.

**Б.Баясгалан:** Сайн байна уу? Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Эрчим хүчний хүчний яамны Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга Баясгалан гэдэг маань Энхцэцэг гишүүний асуултад хариулъя. Эрчим хүчний 2023 оны төсвийн гүйцэтгэлээр эрчим хүчний салбарын нормчлолын санд 114 сая төгрөг төвлөрсөн байна. Энэ нь хуулиараа 0.18 хувийг төвлөрүүлдэг. Тэрний дагуу төвлөрсөн байгаа. Эрчим хүчний стандарт бүрдүүлэх асуудал нь бол одоо эрчим хүчний эдийн засгийн хүрээлэнд уг мөнгө нь төвлөрөөд эрчим хүчний стандартуудыг орчуулж батлагдаад мөрдүүлж явдаг байгаа. Яг 2023 оны хэдэн стандарт батлагдсан орчуулагдсан нь надад яг мэдээлэл алга. Энийг тусгайлан танд хүргүүлъя. Байнгын хороонд хүргүүлъя ээ.

**Б.Жаргалан:** Баярлалаа. Энхцэцэг гишүүн тодруулах уу? Энхцэцэг гишүүний микрофоныг.

**С.Энхцэцэг:** Тэр 1 дүгээр асуулт дээр төрийн өмчит үйлдвэрийн газруудын худалдан авалт дээр нийт хэдэн гэрээг гаднын компаниудтай байгуулсан. Төсөвт өртөг нь хэд байсан энэ тэр гэдэг дээр хариулах боломж байхгүй юу тэ?

**Б.Жаргалан:** Минут нь дуусчихсан байна.

**М.Мандхай:** Мандухай гишүүний микрофоныг өгье асуултаа асууна уу? Сайн байцаана уу? Би эхлээд энэ нөгөө Засгийн газрын санхүүгийн нэгдсэн тайланд аудит хийсэн тайлантай холбоотой Сангийн яамнаас эхлээд асуултаа асуухаасаа өмнө нэг асуулга тодруулаадахъя. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой бүх хуулийн этгээдүүд, түүний нөгөө төсөл, арга хэмжээ, хөрөнгө оруулалт, үндсэн үйл ажиллагааны зардал, зээл тусламжийн

зарлагын гүйлгээг бүгдийг төрийн сангийн харилцах данс ашигладаг уу? Жишээлбэл одоо Эрдэнэт байж болно. МИАТ ч юм уу Эрдэнэтийн ДЦС. Эндээс төрийн сангаар бүх зарлагууд хийгддэг үү гэдгээс асуултаа асуугаад хийгддэг, эсвэл хийгддэггүй гэдгээсээ дөрөөлөөд дараагийнхаа ашигладаг уу гэдгийг асуух гэсэн юм. Айн ашигладаг уу? Тийм үү үгүй юу гэдгийг нь л мэдчихье эхлээд.

Тэгэхээр ашигладаггүй гэж байна. Төсвийн байгууллагууд ерөөсөө ашигладаггүй. Тэгэхээр би юу асуух гээд байгаа гэхлээр батлагдсан төсвийн хүрээнд үндсэн үйл ажиллагааны зардал, энэ хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ сангуудын гүйлгээг бол ер нь төрийн сангийн харилцах дансаар дамжуулан авч болдоггүй юм уу? Ядаж энэ чинь нөгөө гарч байгаа бүх зарлагаа хяналт тавих боломжтой. Гарч байгаа зарлагаа урьдчилж одоо Сангийн яам юм уу Төрийн сан хянах ийм боломжийг нь гаргах эрсдэлээс нь сэргийлэх ийм боломжтой гэж харж байгаа. Яагаад гэхээр зарим байгууллагууд жишээлбэл Солонгос улс дахь нийгмийн даатгалын хэлтэс энэ тэр бол нэг дансанд Монгол руу мөнгөө төвлөрүүлээд тэгэнгүүт нь тэрийг нь сарын эхэнд юм уу эсвэл сарын сүүлээр ингэж авах ийм боломжтой байгаад байдаг юм байна лээ. Жишээлбэл энэ дээр би энэ тайлан дээр харахад аудитын тайланг баталгаажуулах тухай тушаалаар албан шаардлагын жагсаалтын 1 дүгээрт бичигдсэн Эрдэнэт ДЦС-тай холбоотой гүйлгээ бол ерөөсөө анхан шатын бүртгэл хийгдээгүй явчихсан. Тэгээд цаашид энэ асуудал гаргахгүйн тулд ер нь ямар арга хэмжээ Сангийн яам авъя гэж бодож байгаа юм.

Хоёр дахь асуудал болохоор Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгдсэн тайланд хийсэн аудитын тайлангийн нэгдсэн мөнгөн гүйлгээний тайлантай танилцсан. 2023 оны нийт орлого 22 онтой харьцуулахад 17.9 их наяд буюу 40 хувиар нэмэгдсэн. Эндээс нийт зарлага 41 хувьтай 8 хувийн

хэмнэлттэй байгаа ч гэсэн энэ бараа бусдаар ажил үйлчилгээ гүйцэтгэх хураамж гэж байгаа. Энэ дээр 6.2 их наяд төгрөг нэг жилийн дотор 83 хувиар өссөн байгаа харагдаж байна лээ. Энэ өсөлтийн шалтгаан нь яг юу байсан юм? Энэ өсөлтийн задаргаа нь аль байгууллага дээр хамгийн их өндөр гарсан бэ? Эндээс асуулт асуумаар байна. Тэгээд жилийн эцсийн хөрөнгийн тооллого хийгдэж баталгаажууллаа гээд нэлээн олон зөрчилтэй асуудлууд харагдаж байна лээ. Жилийн эцсийн хөрөнгийн тооллого баталгаажсаагүй өмч хамгаалах комисс байгуулаагүй зарим хөрөнгийн тэр тооллогод хамруулаагүй биетээр бараг 803 тэрбум төгрөг, үүний энэ уул уурхай.

**Б.Жаргалан:** Нэмээд нэг минут өгье. Мандухай гишүүний микрофон.

**М.Мандхай:** Энэ 803 тэрбум төгрөгийн эндээс Уул уурхайн сайд 91.3 тэрбум, Хөдөлмөр нийгэм хамгааллын сайд 12.6, олимпын нийтийн биеийн тамир спортын үндэсний хороо 8.4 гээд хамгийн өндөр энэ зардлууд байна. Хөрөнгийг энэ данс бүртгэлд тусгаагүй, төсвийн хөрөнгөөр төлөвлөөгүй хөрөнгө худалдан авсан үндсэн хөрөнгийн шинжтэй 833.3 тэрбум төгрөг байгаад байгаа юм. Энэ дотроос ирвэл Эрчим хүчний сайд 260.2 тэрбум гээд ингээд нэлээн өндөр дүнтэй тэгсэн мөртөө хөрөнгийн данс бүртгэлд тусгаагүй. Энэ их том хөрөнгийг төсвийн хөрөнгөөр төлөвлөөгүй байж худалдаж авсан хөрөнгүүдийг ер нь яах ёстой юм бэ? Энийг албажуулж бүртгэх үү? Энэ дараагийн дахиад шинэ төсөвт орж ирэхдээ яг энэ хэмжээний хөрөнгө худалдан авалтууд хийгдэх вэ? Энэ дээр ерөнхийдөө Сангийн яам ямар арга хэмжээ авч ажиллая гэж бодож байгаа вэ гэсэн энэ асуултаудад хариулаач.

**Б.Жаргалан:** Мандухай гишүүн Сангийн яамнаас нийтдээ 3 асуулт асуулаа, 4 асуулт асуулаа. Сангийн яам хариулъя. 4 номерын микрофоныг өгье.

**М.Мандхай:** Сангийн яамны Төрийн сангийн газрын дарга Цогбадрах Мандхай гишүүний асуултад хариулъя аа. Эхнийх нь тэр ТӨК-тай холбоотой асуудлууд бол зүгээр нягтлан бодох бүртгэлийнхээ хувьд бол бид нар баланс тайланг нь хүлээж авдаг. Ерөнхийдөө тэр санхүүгийн сахилга бат болон бусад бүртгэлийн асуудлууд нь ТӨХ-нд хамаардаг. Ер нь үүнтэй холбогдуулаад хэрвээ бид нар улсын төсвийн орлогыг төрийн санд төвлөрүүлэхдээ тэг үлдэгдэлтэй дансаар дамжуулж түрүүний тэр Солонгосын гэдэг тэнд байгаа мөнгөнүүдийг бид нар өдөрт нь өдөр болгон орой тэг үлдэгдэлтэй дансаар Улс төсвийн төрийн сангийн нэгдсэн дансанд орлогыг төвлөрүүлдэг байгаа. Бусдаар гүйцэтгүүлэх дээр байгаа тэр хүсэлттэй холбоотойг бол нарийвчлан би танд тухайлан яг аль аль яаман дээр юуных байна гэж харахгүй бол одоо бид нар нэгдсэн тайлан дээр харагдахгүй байна. Сая сүүлд тэр хөрөнгө бүртгээгүй анхан шатын баримт дутуу энэн дээр цаашид яах юм гэдэг дээр манай Үндэсний Аудитын газар дээр нөгөө сая тайлан дотор тийм юмнууд байгаа юу? Тэгвэл бид нар бас Үндэсний Аудитын газар маань шалгалтаа хийгээд тэгээд зохих хууль ёсны байгууллагад нь ангилаад ингээд шилжүүлдэг тийм юу байгаа.

**Б.Жаргалан:** Минутаа дуусгачихсан. Баярлалаа. Дараагийн асуулт Отгоншарын Батнайрамдал гишүүний микрофоныг өгье.

**О.Батнайрамдал:** Баярлалаа. Миний асуулт Сангийн яам, Эдийн засаг хөгжлийн яамтай холбоотой. 2023 оны гүйцэтгэлээр төсвийн орлого давж биелсэн. Энд бол мэдээж уул уурхайн салбар хамгийн гол үүргийг гүйцэтгэсэн. Уул уурхайгаас үсэрсэн дагасан орлогууд. Тэгэхээр нэгдсэн төсвийн нийт орлогын 35 хувийг уур уурхай дангаараа бүрдүүлж байгаа юм. Тэр дунд бидний яг нэг ойлгох ёстой юм нь ерөөсөө л энэ бол нүүрсний биет хэмжээ. Төлөвлөж байснаасаа 20 сая тонноор давж биелсэнтэй л ерөөсөө

холбоотой. Тэрнээс биш дэлхийн зах зээл дээр ч юм уу, Хятадын зах зээл дээр үнэ өссөнтэй холбоогүй. Яагаад гэх юм бол үнэ яг яс юман дээрээ 10 хувиар буурсан байгаа юм. Тэгэхээр мэдээж Засгийн газраас явуулж байгаа шинэ сэргэлтийн бодлого ерөөсөө нүүрс цаашаа гаргахад яг хязгаарлагдах хүчин зүйл болж байгаа боомтын холбоотой асуудлууд. Мэдээж Эрдэнэс Тавантолгойг дагасан далд эдийн засгийг ил болгосон уул уурхайн бүтээгдэхүүний Биржийн хууль амжилттай хэрэгжсэнтэй л холбоотой.

Тэгэхээр манай Монгол Улс ерөөсөө уул уурхай нэг ёсондоо шавхагдах баялаг, түүнээс орж ирж байгаа орлогоос эрс хэт хамааралтай болчихсон. Тэгэхээр энэ уул уурхайгаас хамааралтай эдийн засаг ялангуяа орлого даван биелэх тутам илүү хуримтлал заавал бий болгож байх ёстой. Ер нь илүү орлого олох тусам хуримтлал нь тогтвортой өсөж байж буцаад ямар нэгэн савлагаанаас өөрийгөө хамгаалдаг. Тэгээд ч уур уурхайн баялаг Үндсэн хуулиар энэ бол газрын баялгийн өгөөж ард түмэнд шударга оногдох ёстой гэдэг зарчмын дагуу ч гэсэн. Тэгэхээр энэ дээр аудитын 17 дугаар хуудсан дээр нэг сонирхолтой статистик байгаа юм л даа. Бид нар хэдэн хувийг хуримтлуулж чадсан юм? 2022 онд аваад үзэх юм бол бид нар нийт олсон орлогынхоо нэг 16.6 хувийг нь хуримтлуулж чадсан байгаа юм. Ирээдүй өв сандаа болон Төсвийн тогтворжуулалтын санд. Энэ нь ДНБ-ий бараг 5.7 хувьд Монгол Улсад бараг сүүлийн 30 жил анх удаагаа маш том хэмжээний хуримтлалыг бид нар үүсгэж чадсан дүр зураг харагдаж байгаа юм. Тэгчхээд 2023 онд харамсалтай нь энэ дүн буцаад буусан байна л даа. Бид нар 3 их наяд төгрөгийг хуримтлуулчихаад 2023 онд энэ нь буцаад 1 их наяд болоод ДНБ харьцуулах юм бол 1.6 хувь болж буурсан ийм дүр зураг гарч байгаа юм. Гол нь бид нар нэг ДНБ-ий 5 хувьд хэмжих хуримтлалыг цаашаа үргэлжлүүлээд явах юм бол энэ өөрөө маш сайн хэрэг л дээ. Маш сайн хэрэг. Макро эдийн засгийн

тогтвортой байдлын хүрээнд ч гэсэн. Тэгээд Жаргалан гишүүн ээ би нэмээд нэг минутаа үргэлжлүүлээд авчихъя, нэгдүгээрт.

Хоёрдугаарт нэг асуулт нь Аудитын дүгнэлтийн 46 дугаар хуудсан дээр байгаа. Гадаад зээлийн үлдэгдэл. Эндээс сонирхолтой үр дүн харагдаж байгаа юм. Монгол Улс олон улсын гэрээ хэлэлцээр хийгээд Засгийн газар нэг ёсондоо 20 орчим их наяд төгрөгийн зээлийн хэлэлцээр гэрээнүүд хийгдчихсэн гэсэн үг. 2023 оны тайланд бол яг бид нар 1.2 их наяд төгрөгийг л гадаад зээлээ ашиглаж байна гэсэн үг л дээ. Том зургаар аваад үзэх юм бол бид нар нийт тэр гадаад зээлийнхээ 5 хүрэхгүй хувийг л ашиглаж чадаж байна гэсэн үг. Тэгэхээр сая Уянгахуушиг гишүүн ч асууж байна л даа. Сая 1 төслийг нь дурдаж байна. Зарим нь ингээд гадаад зээлийн ашиглалтад гарахгүй байна гээд. Тэгэхээр ер нь бид нар ямар зүйл рүү орчихсон байна вэ гэхээрээ бараг чөтгөрийн тойрог маягийн. Нийт орлогын 80 хувь нь урсгал зардал руугаа явчхаад үлдсэн 20 хувь дээрээ ерөөсөө 1 жижигхэн тойргийн төслүүд яваад гадаад зээл дандаа хөгжлийн томоохон төслүүд байдаг. Иийшээгээ ерөөсөө орон зай өгөхгүй байсаар байгаад бид нар яг өнөөгийн нүүр царайтай өнөөдөртөө ингээд тулж байна л даа. Тэгэхээр цаашаа энэ том төслүүд явахад аль түүрүүн бид нар энэ гадаад зээлээ бид нар хэрхэн цаашаа ашиглах юм?

**Б.Жаргалан:** Сангийн яам хариулъя. 3 номерын микрофон.

**С.Тулга:** Батнайрамдал гишүүний асуултад хариулъя. Сүүлийнх нь асуултаас эхлээд хариулъя. Таны хэлж байгаа яг одоо манай Засгийн газрын гэрээтэй нийтдээ яах вэ яг 2023 ондоо нийтдээ 140 төсөл байсан. Өнөөдрийн байдлаар 130 төсөл байгаа. Зарим төсөл нь дуусаад зарим нь шинээр эхлээд. Тэгээд ингээд нийтдээ бол яг 10.2 их наяд төгрөгийн ашиглах боломжтой үлдэгдэл

байгаа. 13 их наядын яг хэлэлцээрийн шатанд явж байгаа энэ төслүүд байгаад байгаа тэгээд яах вэ та сая анзаарсан байх. Нөгөө энэ төсвийн тодотгол дагуулаад өгсөн Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулж байгаа энэ хууль дээр яг одоо нөгөө төсвийн зарлагын хязгаар тооцох аргачлалтай энэ гадаад зээлийн ашиглалтын хэмжээг оруулахгүйгээр бид нар ингээд төсвийн нөгөө суурь тэнцэл дээрээ нэмэх 2 хувьтай гаргаад тэгээд тэр гарсан ашгаараа эргээд зээлээ төлөх байдлаар ингээд явна гээд явсан. Тэгээд энэ жил жишээлбэл яг 1.2 их наядын зээлийн ашиглалт хийхийг 984 тэрбумаар нэмэгдүүлээд 2.2 их наяд болгосон. Тэгээд яг төсөв таны хэлдгээр ингээд урсгал зардал талдаа зарлага маань ингээд тулчхаад хөрөнгө оруулалтын зардлаа бид нар ингээд нэмж чадахгүй байсныг сая бол ингээд төсвийн тодотголоор одоо ингээд хэрвээ маргааш Их Хурлаар батлагдвал энэ маань ингээд шийдэгдээд явах бүрэн боломжтой болж байгаа.

Тэгэхээр яах вэ бид нар бол энэ 130 төслийн ер нь бол 71 хувь нь ер нь дандаа дэд бүтэц эрчим хүчний томоохон төслүүд байгаад байгаа. Томхноос нь дурдвал энэ Төв цэвэрлэх байгууламж Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц газрын тос боловсруулах үйлдвэр гээд энэ том том бүтээн байгуулалтын ажлуудыг бид нар санхүүжилтийг нь дандаа гадаадын тусламжаар хийж байгаа учраас ашиглалтыг нь ингээд төсөв тал дээрээ хийгээд явах ийм боломжийг нээсэн байгаа. Тэгэхээр бид нар одоо бол ирэх жилүүдэд ер нь бас 2.2 их наядаасаа буухгүйгээр энэ суурь хэмжээндээ юм уу эсвэл түүнээс дээших хэмжээнд ингээд гадаад зээлийн ашиглалтыг хийгээд явах ийм төсөөлөлтэй байгаа юм аа. Эхний асуултыг манай төсвийн.

**Б.Жаргалан:** 4 номерын микрофоныг өгчихье.

**В.Рэнцэнханд:** Өдрийн мэнд та бүхэн Батнайрамдал гишүүний асуултад хариулъя.

Монгол Улс бол төсвийн тусгай шаардлагаараа үнийг тэнцвэржүүлсэн журмаар тооцдог байгаа. Тэгэхлээр өнгөрсөн жил 2023 оны байдлаар гэхэд бол манай гол нэр төрлийн түүхий эдийн үнэ тэнцвэржүүлсэн журмаар тооцоход бол жишээлбэл нүүрсний үнэ 110.8 ам.доллар. Зэсийн үнэ 8386.7 ам.доллороор бид нар тэнцвэржүүлсэн үнийг тооцсон. Тэгэхдээ зах зээлийн яг дэлхийн зах зээлийн дундаж үнэ жишээлбэл нүүрсний үнэ 144 доллар тэгээд зэсийн дундаж үнэ 8500 байсан буюу манай зах зээлийн үнэ бид нарын тооцсон тэнцвэржүүлсэн үнээс илүү байсан учраас энэ нь бол манай тогтворжуулалтын санд хуримтлал хэлбэрээр орсон байгаа. Тэгээд 2023 оны эцсээр Тогтворжуулалтын сан 676 орчим тэрбум төгрөг бол тогтворжуулалтын сандаа орсон. Тогтворжуулалтын сангийн үндсэн зорилго бол мэдээж уул уурхайн савлагаанаас хамгаалагдсан байдлаар хэрвээ уул уурхайн үнэ тодорхой хэмжээнд 20 хувиас доошоогоо буугаад төсвийн орлого тасалдах нөхцөлд бид нар тогтворжуулалтын сангаас авч хэрэглэгдэх хуулийн зохицуулалттай.

Тэгээд 2023 оны эцсийн байдлаар уг тогтворжуулалтын санд бол 1.6 их наяд төгрөг хадгалагдаж хуримтлагдсан байгаа. Үүнээс гадна бол ирээдүйн өв сан Үндэсний баялгийн сан дээр одоогийн Ирээдүйн өв сан дээр 3.6 их наяд төгрөг 2023 оны байдлаар хуримтлагдсан байгаа. Ер нь Монгол Улс уул уурхайгаас бүрэн хамааралтай нь үнэн. Гэхдээ бид нар уул уурхайн энэ үнийн циклээс хамгаалагдсан байдлаар хуримтлалын сантай.

Дээрээс нь бүх олсон орлогоо тухайн жилдээ зарцуулахгүй байхаар хуримтлуулдаг байхаар эхэлсэн тогтолцоотой гэдгийг л хариулж дууслаа. Баярлалаа.



**Б.Жаргалан:** Баярлалаа. Энэ гадаад зээлийн ашиглалттай холбоотой нэмж хэлэхэд Монгол Улсын нийт гадаад өр төлбөрийн хэмжээ 33 орчим сая тэрбум доллар байгаа. Тэгээд энэ 2023 оны төсвийн гүйцэтгэл дээр зээлийн үйлчилгээний төлбөрт 1 их наяд 150 тэрбум төгрөг зарцуулчихсан байж байгаа. Тэгэхээр зээлийн үйлчилгээний төлбөр манай төсвийн урсгал зардлын 6, 7 хувийн ийм зардлыг эзэлж байгаа. Тэгэхээр энэ дээр бас анхааралтай баймаар байна аа.

Хассуурийн Ганхуяг гишүүн.

**Х.Ганхуяг:** Төв банк, төрийн өмчийн зохицуулах хороо, Сангийн яам асуултад хариулна шүү. 2022 онд 16 дугаар тогтоолоор 25 аж ахуйн нэгж төрийн өмчит аж ахуйн нэгж хөрөнгийн бирж дээр нээлттэй хувьцаат компани болгохоор тогтоол гарсан байдаг. Төрийн банкнаас өөр ямар нэгэн үйлдэл хийгдсэнгүй. Энэ дээр хариултаа бэлдэх үү? Нийтийн Төрийн өмчит компаниуд чинь 5 зуугаад тэрбумын алдагдалтай ажилласан байна шүү дээ. Тэгээд жил болгон төсөв хэлэлцэх үеэр ашиггүй хувьчилна аа л гэдэг. Тэгээд алдагдлыг нь улсын төсвөөс нөхөөд яваад байдаг. Улсын төсвөөс нөхөхөөс гадна Эрдэнэс Тавантолгой гэдэг компани үндсэндээ нэг банк болчихоод байна шүү дээ. Яг одоо болохоор 2.7 их наяд төгрөг, бусад ТӨК-удыг санхүүжүүлэхэд зарцуулчихсан байна. Энэ дээр нэг Төрийн өмчийн хорооноос би нэг тайлбар авмаар байна.

Хоёрдугаарт энэ ЖДҮ сан гээд хэдэн он жилийн өмнө ч билээ нэг баахан асуудал яригдаад л байдаг. Одоо ч гэсэн ингээд л 58 хувь нь муу зээлийн ангилалтай болчихсон яваад л байдаг. Засгийн газрын тусгай 27, 28 сантай болчихлоо л доо. Тэгээд ихэнх нь бүх яамдууд барилга барьдаг, бүх яамдууд зээл олгодог. Банкны үйл ажиллагаа л явуулдаг болчихлоо. Энэ 27, 28 сангаас чинь зөвхөн 10 сана л яг хуулийн зохицуулалтаар журамлаад явж

байгаа. Бусад нь бүгдээрээ сайд нар нь өөрсдөө журмаа бичээд өөрөө батлаад өөрөө төслөө хэрэгжүүлдэг. Тэгээд энэ орж ирсэн та нар тайлангууд дээр нь харсан уу? Бүх сангууд чинь асуудалтай шүү дээ. Тэгээд энэ цаашидаа ингээд энэ чигээрээ яваад байх юм уу яах юм. Энэ дээр нэг тайлбар авчихмаар байна. Энэ Чингис хаан банктэй нэлээн олон асуудал байна даа. Муу авлага муу зээл гээд 100 гаруй тэрбум байна. Тэгсэн мөртөө дахиад 200 тэрбум төгрөг байршиж байна эрсдэлд орох вий гээд энэ тайланд орчихсон байна. Энэ хэн гэж хүний ямар банк болоод ингээд төв банк хуулиа хэрэгжүүлдэггүй юм. Дөлгөөн дарга аа. Та нар чинь өөр арилжааны банк бус очоод л томилоод л учир начрыг нь олчихдог биз дээ. Энэ яагаад ингээд яваад байдаг юм. Яагаад энэ банкна дээр очоод та нар хана мөргөсөн юм шиг хуулиа хэрэгжүүлэхээ больчихоод байна. Энэ Бэрэн гээд нэг компани байна. 239 тэрбум гээд. Хэн хэн ямар ямар сайдуудын үед энэ олгосон зээл байдаг юм. Дамжуулан зээл олгочихсон байж байдаг.

Сангийн сайд, Барилга, хот байгуулалтын сайд гээд 2 сайдын тушаал дээр зээл олгосон байна. Тэгээд одоо мөнгөө авч чаддаггүй. Тэгээд энэ анхан шатны баримтгүй 243 тэрбум.

**Б.Жаргалан:** ТӨХ-ноос хүн байгаа юу? Сангийн яамны төрийн сангийн төлөөлөл хариулъя. Сая Төрийн сан сангийн төлөөлөл байсан уу? 4 номерын микрофоныг дахиад өгье.

**С.Тулга:** Сангийн яамны хэлтсийн дарга Тулга. Гишүүний асуултад хариулъя. Улсын Их Хурлын 16 дугаар тогтоолын биелэлт дээр Сангийн сайдын харьяа 3 компани орсон байгаа. Хөрөнгийн бирж, Төрийн банк, Үндэсний давхар даатгалын 3 компани орсон байгаа. Хөрөнгийн бирж 34 хувиа амжилттай арилжаалж олон нийтийн оролцоотой компани болсон. Төрийн банк 5 хувиа арилжаалж олон нийтийн оролцоотой компани болсон. Үндэсний давхар

даатгалын IPO-г хийхээс яг өмнөхөн бүх банкнуудын IPO гарсантай холбогдуулан маркет хөдөлчихлөө. IPO амжилттай болгох боломжгүй болсон гэсэн судалгааны үндсэн дээр IPO гаргах асуудлыг түр хойшлуулсан байгаа. Бусад компаниудын хувьд ерөнхийлөн захирчид хариулах байх аа. Бэрэн групптэй холбоотой дамжуулан зээлийн хувьд Ганхуяг гишүүн ээ Сангийн яам бол Зам тээвэр, барилга хот байгуулалтын тухайн 2012 оны нэршилээр нь ингээд дээшээ зээлээ өгчхөж байгаа юм. Тэндээс яг төсөл хэрэгжүүлэгч компаниуд руу нь ингээд зээл гарч байгаа. Тэр нь болохоор Хятадын Засгийн газрын хөнгөлөлттэй зээл байсан. Тэр дамжуулан зээлийн гэрээнийх нь хуулбарыг би танд хүргүүлье.

Гэрээ нь яг алга байна. Би тэгэхдээ танд нягтлаад хэлээд өгье.

**Б.Жаргалан:** Тусгай сангуудтай холбоотой асуулт байсан.

**С.Тулга:** Тусгай сангуудын хувьд Сангийн яамны харьяанд 3 тусгай сан байгаа, Ирээдүйн өв сан байгаа, Төсвийн тогтворжуулалтын сан байгаа. Тэгээд Засгийн газрын нөөц сан байгаа. 3 сан нь гурвуулаа хуулиар зохицуулагддаг. Ирээдүйн өв сан, Тогтвортой байдлын сан 2-оос зарлага гардаггүй. Засгийн газрын нөөц сангийн зарлага бол тухайн үед Засгийн газрын тогтоол гарч зарлага гардаг ийм сан байгаа.

**Б.Жаргалан:** Монгол банкнаас хэн хариулах вэ? Монгол банкны ерөнхий эдийн засагч Ган-Очир 4 номерын микрофон.

**Д.Ган-Очир:** Сайн байна уу? Монголбанкны ерөнхий эдийн засагч Ган-Очир байна. Ганхуяг гишүүний асуултад хариулт өгье.

Чингис хаан банканд дээр эрүүл мэнд нийгмийн даатгалын сангийн 96.5 тэрбум төгрөг ЭМД-ын сангийн 30.9

тэрбум төгрөг төлөгдөөгүй үлдэгдэлтэй байгаа гэдэг мэдээлэл бидэнд байгаа. М банкны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд ерөнхийдөө сүүлийн 3 орчим жил зөрчигдөөд явж байгаа. Тэгэхдээ Монголбанкнаас барьж байгаа, барьж ирсэн бодлого бол эхний ээлжид М банк, шинэ хувьцаа эзэмшигчтэй болно гэдэг мэдээллийг удаа дараа ирүүлдэг. Зарим тохиолдолд шинэ хувьцаа эзэмшигчдийн сонирхож байгаа уулзалтуудыг хийх, тайлан, холбогдох материалууд, эх үүсвэр шалгуулах зэргээр Монгол банканд байнга хандаж ирдэг. Тэгээд хувьцаа эзэмшигчид ТУЗ-ийн зүгээс бол байнга шинэ хувьцаа эзэмшигчтэй холбоотой мэдээлэл ирдэг. Тэгээд энэ тохиолдолд Монгол банкны үйлчилж байгаа дүрэм журмаар бол мэдээж шинэ хувьцаа эзэмшигчдээ өөрийн хөрөнгө нь сайжраад үйл ажиллагаа нь хэвийн болох тохиолдолд татан буулгах гэдэг үйл ажиллагаа руу орохгүй байх зохицуулалттай. Тэгэхээр ийм хэлбэрийн уулзалт явдаг.

Хоёр дахь тохиолдолд мэдээж Монголбанкнаас шаардлагуудаа бол удаа дараа тавьдаг. Энэ нь бол балансаар ялангуяа зээлийн барьцаанд ирсэн байгаа хөрөнгүүдийг зарж борлуулах. Үүнээс олсон орлогыг Банкны тухай хууль болон бусад холбогдох хууль дээр байгаа эргэн төлөлт хийх өр төлбөрийн дараалал гэж байгаа. Энэ дарааллын дагуу өр төлбөр төлөх ёстой. Өрийн дараалал нь бол хамгийн эхлээд иргэд дотроо харилцах тэрний дараа хадгаламж хадгаламжийн богино хугацаанаасаа дунд, урт хугацаатай хадгаламж тэгээд аж ахуйн нэгж гээд ингээд явдаг. Тэр нь бол одоо Засгийн газрын данснууд, энэ төрийн өмчит байгууллагуудын данснууд бол нэлээд дарааллын хойно байдаг учраас эдгээрийн эргэн төлөлт хуулийнхаа тэр заалтынхаа дагуу бол хийгдэхгүй явж байгаа асуудал байгаа. Банк бол.

**Б.Жаргалан:** Ганхуяг гишүүний тодруулга.

**Д.Ган-Очир:** Танд наад хүргүүлсэн байгаа аудитын тайлан дээр чинь яг 200 тэрбум байришиж байгаа гээд орсон байгаа. Хөгжлийн банкнаас 50 тэрбум авсан гэдэг олон нийт бүгдээрээ мэдэж байгаа. Та болохоор зөвхөн ЭМД-ын сан, нийгмийн даатгалын сан яриад байна. Өөр төрийн өмчит ямар компаниудаас хэдэн төгрөг байришиж байгаа юм. Энийг тодорхой мэдээл өгөх үү. Тэгээд яагаад яг Чингис Хаан банкны асуудал ярихаар та нар ингээд дандаа буруу зөрүү мэдээлэл хүмүүсийг ингээд төөрөгдүүлсэн мэдээлэл өгөөд байдаг юм? Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Сангийн яам энэ банкнуудын харилцах дансны дээд хүү 3 хувиар тогтоосон байна. Тийм юм байгаа юу Ган-Очроо? Тэгээд та нар тийм учраас наад дээрээ нэг 200 тэрбум байришуулаад нэг бол энэ банкиг аврах үйл ажиллагаа явуулаад байгаа юм уу? Эсвэл ашигт ажиллагааг нь сайжруулах гээд ингээд яваад байгаа юм уу? Наад учир начраа нэг аятайхан хэлээдхээч.

**Б.Жаргалан:** 4 номерын микрофон Монголбанк.

**Д.Ган-Очир:** Би дөнгөж сая 2 сангийн л үлдэгдлийг хэлсэн. Мэдээж аудитын газрын дүгнэлтээр гарч байгаа энэ дүнг мэдээж хүлээн зөвшөөрч байна. Энэ доторх нарийн задаргаа мэдээлэл нь яг одоо надад байхгүй байгаа болохоор шаардлагатай бол танд албан тоотоор дэлгэрэнгүй мэдээллээр ер нь хүргүүлж болно. Банкуудын харилцах данс бол харилцах дансны хүүг тогтоож байгаа бол Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн байгууллагуудын зүгээр ийм байдлаар тогтоосон тийм үйлчлэл бол одоогоор явж байгаа.

**Б.Жаргалан:** Ганхуяг гишүүн нэг минут.

**Х.Ганхуяг:** Би энэ өмнө нь асуухаар дандаа л хүмүүсийг гөлөг төөрүүлсэн л юм хариулаад байгаа юм л даа. 2011 онд 94 тэрбум байришуулсан байгаа юм. Тэгээд муу зээлийн ангилалд

орсон байгаа юм. Тэгээд 2014, 2015 онд дахиж олгоод 2016 онд дахиж олгоод дээрээс нь Хөгжлийн банкнаас зээл олгоод ингээд дээрээс нь ТӨК-удаас өмнөх зээлээ авч чадахгүй муу ангилалд орчихсон. Тэгээд дээрээс нь ингээд ТӨК-удын мөнгийг байришуулаад төсвийн байгууллагын мөнгийг байришуулаад ингээд 200 тэрбум төгрөг байришуулчихсан байгаа байхгүй юу. Та нар хууль хэрэгжүүлэх үүрэгтэй гэдгийг чинь би өмнө нь хаврын чуулганаар хэлж байсан тийм ээ? Та нар дуртайг нь хэрэгжүүлээд дургүйг нь ингээд хэрэгжүүлэхгүй яваад байдаг юм уу айн? Яагаад яг ийм банк дээр очихоороо хууль нь хэрэгжихээ больчихдог юм? Яагаад зохистой харьцаагаа хэрэгжүүлэхээ больчихдог юм. Яг тодорхой хариулна шүү Ган-Очироо.

**Б.Жаргалан:** 4 номерын микрофон.

**Д.Ган-Очир:** Тийм. Зүгээр яг энэ байришуулалттай холбоотой асуудлууд бол яг л төрийн байгууллагууд. Төрийн хариуцсан сангуудынх нь л үйл ажиллагаа байгаа. Монголбанкны хувьд бол тухайн банкны хэвийн үйл ажиллагаа, харилцагчийн эрх ашгийг хамгаалахын тулд дүрэм журмуудыг л мөрдүүлж байгаа. Тэр агуулгаараа бол мэдээж тэр байришуулалттай холбоотой асуудлууд таны хэлдэг сүүлийн 10 гаруй жилийн хугацаатай асуудлуудыг холбогдох байгууллагууд нь шалгаж дүгнэлтээ гаргах ёстой байх. Тухайн банкны хууль журмын хэрэгжилтийг миний сая хэлдэг шалтгаануудаар хойшлуулах үндэслэлүүд хууль дүрэм журам дотор байгаа учраас л хойшлуулаад яваад байгаа. Зүгээр тодорхой яг аль хуулийн аль заалт, аль журам гэдгийг бол. Монголбанк байришуулаагүй гэдгийг л би энд онцолж хэлэх гээд байна. Яг Монголбанкны барьдаг байр суурь гишүүн ээ Монголбанк албан ёсоор лиценз өгсөн санхүүгийн байгууллагуудыг бол яг ижил түвшинд л авч үзэх ёстой. Хэрвээ хууль болон бусад журмаар бол үйл ажиллагаа болон бусад зүйлийг хязгаарлахаар нөхцөл байдал

үүсээгүй л байгаа. Тэгэхээр энэ таны хэлж байгаа нөхцөл байдал бол арван хэдэн онуудад бүгд байриччихсан. Энэ банкны нөхцөл байдал бол 2021 оноос.

**Б.Жаргалан:** Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлантай холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгье. Үг хэлэх гишүүдийг Энхцэцэг гишүүнээр тасаллаа.

Соронзонболд гишүүн үгээ хэлнэ үү?

**Л.Соронзонболд:** Энэ Үндэсний аудитын нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан дээр ч тэр байсан нэг асуудал юу байсан бэ гэхээр нөгөө энэ Монгол Улсын Засгийн газар өөрөө бүртгэлээ мөнгөн суурьтай бүртгэл хийдэг юм байна аа гэж. Тэгэхээр олон улсын бүртгэлийн стандартад ойртуулж бүртгэлээ хийвэл энэ Засгийн газрын нэгдсэн санхүүгийн тайлан ч тэр нэгдсэн төсвийн гүйцэтгэл ч тэр арай өөр гарах байх гэж бодож байгаа. Тийм учраас энэ тал дээр бас холбогдох газрууд нь анхаарах ёстой байх гэж бодож байна. Тэгээд энэ төсвийн ерөнхийдөө гүйцэтгэл ингээд харахаар аягүй сайн харагдаад байгаа. Гэхдээ яг бодит байдал дээр бол зүгээр ер нь бид нар өөрсдөө уул уурхайн салбараас их хамаарч байгаа учраас манай энэ орлогын татварын орлогууд маань ингээд давж биелээд байгаа харагдаад байгаа. Тэгээд яг үнэхээр бодит суурь маань ямар байна вэ гэдгийг бид нар сайн бодохгүй бол ялангуяа жижиг, дунд ААН-үүд ер нь нэмэгдсэн өртгийн албан татварын өр, НДШ-ийн төлбөр 2 бол ер нь маш дарамттай байна гэдэг зүйлийг их ярьж байгаа. Ихэнх томоохон байгууллагуудын хувьд энэ асуудал харьцангуй гайгүй байдаг байх.

Тийм учраас энэ тал дээр ер нь яг одоо энэ тухайн асуудлуудыг хариуцсан холбогдох газрууд ялангуяа жижиг, дунд

ААН-үүдийн хувьд энэ нэмэгдсэн өртгийн албан татварын төлөлт дээр НДШ дарамт болоод байгаа дээр ер нь тодорхой бодлогын санал гаргаж танилцуулах ёстой байх гэж бодож байна аа. Тийм саналтай үг хэлье ээ.

**Б.Жаргалан:** Соронзонболд гишүүнд баярлалаа.

Баатаржавын Мөнхсоёл гишүүн.

**Б.Мөнхсоёл:** Хоёр хурлын дунд гүйгээд байлаа. Төсвийн байнгын хороо яг ид хуралдаж байна. Тэгэхээр товчхон давхардуулахгүй хэлэхийг хичээхэд ерөнхийдөө ТӨХК-тай холбоотой төрийн өмчийн ААН-үүдтэй холбоотой асуудлууд нэлээн хөндөгдөж байна. Тэгээд энэ бүхэлдээ аудитын газрын гаргасан тайлан бол хязгаарлагдмал хүрээнд гэж байна шүү дээ. Тэгэхээр бүрэн бүтэн дүгнэлт өгөөд зөвлөмж гаргахад бол хэцүү байна гэж харсан. Зүгээр одоо энэ Төрийн өмчит компаниуд 25 субъект байгаа шүү дээ. Тэгээд тэрэн дээр 9 гол яамдын сайд нар нь өөрсдөө бодлого зангидах зохицуулалт хийх энэ хувьцаа эзэмшигч юм шиг тэр ТУЗ-д нь суухаар ер нь шийдвэр өөрөө өөрсдийгөө нөгөө хянах механизм нь хэр зөв ажилладаг юм бол оо. Ер нь одоо энэ ирэх оноос өгсүүлээд зарим хувьцааг олон нийтэд зарах нээлттэй болгох замаар энэ төрөөс хамаарсан байдлыг нь багасгахгүй бол нөгөө төлөвлөгөө ёсоор төвлөрүүлэх ёстой байсан мөнгө бол ноогдол ашигийн тал хувь нь бүрдээгүй ирээдүйн өв сан дээр 4-ний 1 хувь нь бүрдээгүй гээд олон асуудлууд байна шүү дээ тиймээ? Энэ асуудлууд ирэх онуудад үргэлжлэх ийм байдалтай байна аа. Өөрөөр хэлэх юм бол хамгийн товчоор хэлэхэд энэ ТӨК-удын засаглалын асуудлуудыг сайжруулах шаардлагатай байна гэж хэлмээр байна.

Хоёрдугаарт нь болохоор үүнтэйгээ ч холбогдуулаад бусад энэ гишүүдийн хэлсэнтэй ч холбогдуулаад энэ 2023 оны төсвийн гүйцэтгэлийг илүү хэлэлцэхээс гадна ялангуяа 2024, ирэх

онуудын хөрөнгө оруулалттай холбогдуулаад шалгуур үзүүлэлтүүдийг хөрөнгө оруулалтын төслүүдээ эрэмбэлэхэд маш сайн анхаарах үргэлжлүүлээд маш сайн тодорхой болгох үүн дээрээ эх үүсвэрүүдийг нь маш сайн тодорхой дурдаж байх нь эргээд энэ тухайн төсвийн тогтвортой байдлын хууль ч байна уу, ирэх онуудын Төсвийн тухай хуулиудыг хэлэлцэхэд ч байна уу маш их нэмэртэй байх. Түрүүн энэ Батнайрамдал гишүүн бас хэлчихлээ шүү дээ? Нэг талдаа бид нар төсвийн сахилга батыг баримаар байдаг. Нөгөө талдаа нэгэнт хэлцэл нь явагдчихсан энэ гадаадын зээл рүү ашигламаар байдаг. Гэтэл нөгөө хяналт хариуцлагын механизм нь сул, нийтээрээ иргэдийн дунд итгэлцэл, төр засагтаа ч, улс төрчдөдөө ч итгэх итгэл нь багасчихсан энэ үед яг энэ саяын энэ реформын шинжтэй зүйлүүдийг ярихад маш хүнд болчихлоо шүү дээ. Тэгэхээр энэ хөрөнгө оруулалтын төслүүдээ эрэмбэлэх нийтэд ил тод мэдээлэх тэгээд энэ шинээр гаргаж ирж байгаа реформын шинжтэй зүйлүүдээ олон нийтэд маш ойлгомжтой байдлаар танилцуулах тэгээд болж өгвөл энэ Их Хурал дээр олон нийтэд хэлэлцэгдэх ёстой энэ хугацааг илүү сунгаж өгөх яаруу горимоор биш хэлэлцдэг байх гэсэн энэ гол зарчмын шинжтэй саналуудыг хэлье ээ.

**Б.Жаргалан:** Баярлалаа. Батнайрамдал гишүүнийг нэмж үг хэлэхээр бүртгэчихье.

Тэгээд одоо Энхцэцэг гишүүний микрофоныг нээе.

**Э.Энхцэцэг:** Би ерөнхийдөө сүүлийн жилүүдэд цахилгаанаас үүдэлтэй гал түймэр маш их гарч иргэд хөрөнгө санхүүгийн хохирол их амсаж байгаа. Мөн цахилгаан гүйдэлд хүн тогонд цохиулах, нас барах, гэмтэж бэртэх асуудал маш их гарч байгаа. Тэгэхээр тухайлбал одоо сүүлийн жилүүдэд сүүлийн 10 жилд улсын хэмжээнд 8 мянга гаран цахилгаанаас үүдэлтэй гэмтэл гарч 80 гаран тэрбум

төгрөгийн хохирол учирсан байна. Мөн онцгой байдлын газар 5 орчим тэрбумын зардал гаргасан байна. 200 гаруй хүн нас барсан байна, 200 гаруй хүн гэмтэж бэртсэн байна гээд. Тэгэхээр энэ асуудлыг байхгүй болгох зорилгоор хамтарсан Засгийн газар үйл ажиллагааны хөтөлбөртөө энэ эрсдэлийг байхгүй болгох тогтолцоог бий болгох реформ хэрэгжүүлэх гээд тусгасан байгаа. Тэгэхээр энэ хүрээнд бол стандартыг орчин үеийн түвшинд хүргэх, тогтмол сайжруулж явах стандартаар бүх л оролцогч талуудын мэдлэгийг сайжруулах үйл ажиллагаандаа тогтмол хэрэглэх, хэрэглэж байгаа байдалд нь тогтмол хяналт тавих гэх мэтчилэнгээр ийм цогц үйл ажиллагааг хийж байж энэ байдлыг байхгүй болгож ард иргэдээ аюулгүй тийм нийгмийг бий болгох юм байгаа юм. Тэгэхээр энэ тал дээр Барилга, хот байгуулалтын яам, Эрчим хүчний яам болон бусад холбогдох газрууд бас хамтарч ажиллаж үйл ажиллагааныхаа нарийн төлөвлөгөөг гаргаж төсөв төлөвлөгөөгөө сайн тусгаж орж ирж хамтарч ажиллаасай гэж хүсэж байна.

Дараагийн нэг асуудал болохоор энэ чанарын хяналтын асуудал чанарын хариуцлагын асуудал. Одоогийн байдлаар бол төсөв ажлаа гүйцэтгээгүй чанаргүй гүйцэтгэчихсэн компаниудтай тухайн гэрээг цуцлах байдлаар хариуцлага тооцож байгаа гэж харагдаж байгаа. Тэгэхээр энэ хариуцлагыг тухайн компанийн тусгай зөвшөөрөлтэй нь уяж өгөөч ээ. Тусгай зөвшөөрлийг цуцлах асуудлыг хөндөж тавиач ээ. Тэгэхгүй бол тухайн гэрээгээ цуцлуулчихаад л дараа дараагийн тендерүүд ороод дараа дараагийнхаа чанаргүй барилгыг бариад улсын хөрөнгийг үргүй зарцуулаад ингээд яваад байдаг асуудал байдаг. Тэгэхээр дараагийн аудитын гүйцэтгэл дээр юу харахаа хүсэж байна гээд тэгэхээр яг үнэхээр ийм чанаргүй гэрээт ажлаа гүйцэтгэж чадаагүй гэрээгээ цуцлуулсан тэр байгууллагуудын тэр компаниудын тэр тусгай зөвшөөрлийг цуцалсан тухай

асуудлыг хөндөж орж ирвэл зүгээр харагдаж байна.

Дараагийн нэг асуудал нь болохоор одоо энэ төрийн өмчит үйлдвэрийн газруудын зардлын асуудал, зардлын ил тод шилэн байх асуудал, бүтээмжийг дээшлүүлэх асуудлыг нэлээн сайн өндөр түвшинд авч үзээч ээ. Бид нар одоо тухайлбал эрчим хүчний салбарт бид нар үнэ тарифыг зохих түвшинд хүргэх алдагдалгүй болгох гээд асуудал яригдаж байгаа. Тэгэхээр мөн эрчим хүчний реформ хийх тэгэхээр эрчим хүчний реформ хийх нэг том зорилго бол нэг том зорилт бол тухайн салбарын энэ зардлыг бууруулах, бүтээмжийг дээшлүүлэх, энэ зардлын хяналтын системийг сайжруулах асуудал байгаа. Тэгэхээр энэ асуудлыг сайн хөндөж үйл ажиллагаанууд хийж хэрэгжүүлсэн байдлаар цаашидаа явбал зүгээр байна гэсэн ийм саналуудыг хэлэхийг хүсэж байна аа.

**Б.Жаргалан:** Баярлалаа.  
Батнайрамдал гишүүн.

**О.Батнайрамдал:** Баярлалаа. 2 зүйл хэлэх гэсэн юм. 1 дүгээрт аудитын тайлан уншлаа. Ер нь сүүлийн 10 жилд бас нэлээн олон аудитын тайлан харж байсан. Ялангуяа боловсролын зээлийн сантай холбоотой бараг арваад жилийн Үндэсний аудитын газраас гаргасан тайлан зөвлөмжийг маш сайн судалж байсан. Ер нь Үндэсний аудитын газрын тайлан дээр бол асуудлууд бүгдээрээ маш ойлгомжтой байдаг юм байна лээ. Аягүй сайн тусгаж өгдөг хамгийн гол нь ерөөсөө асуудал нь ингээд нэг удаа бид нар хэлэлцчихээд тэгээд хаячихдаг. Тэрийг дахиад хэн ч гаргаж ирдэггүй. Тэрний ардаас хэн ч хөөцөлддөггүй. Буцаад зөвлөмж нь хэрэгждэггүй дээр л ерөөсөө хамгийн том асуудлууд байдаг юм байна лээ л дээ. Жишээлбэл тэр боловсролын зээлийн сангийн асуудал бол аль 2011, 2012 оны 2003, 2004 оны аудитоор бүгдээрээ жишээтэйгээ байсан. Тэрийг зүгээр хэн ч гаргаж ирж дүн шинжилгээ хийгээд тэрний араас хөөцөлддөг байхгүй

юу. Тэрнээс биш аудитын газар бүгдийг нь маш дэлгэрэнгүй тайлбарлачихсан байгаа юм. Тэгэхээр энэ аудитын тайлан уншсан ч гэсэн асуудлууд маш ойлгомжтой энэ дээр байна л даа. Тэгэхээр энэ дээр өмнөх онд хийсэн аудитаар нийт 17 зөвлөмж хүргүүлснээс ер бүрэн хэрэгжсэн 17-оос 3 л байгаа юм. Хэрэгжих шатдаа 11 нэг жилийн дотор бүгд хэрэгжихгүй. Хэрэгжээгүй 3. Нийт зөвлөмжийн биелэлт бол 60 хувьтай байна гэж аудитын газар бас Аудитын газар дүгнэсэн байна л даа. Тэгэхээр энэ хувийн ардаас л бид нар хөөцөлдөх ёстой юм байна лээ л дээ. Энэ 60, 70, 80. Ингээд явах тусам бид нарын асуудлууд бол угаасаа ойлгомжтой. Энэ аудитын дүгнэлт дээр байдаг. Шийдэж болох асуудлууд байгаа юм.

Хоёрдугаарт яг энэнтэй хамтдаа яг параллелийн юу хийгдэх ёстой вэ гэхээр нөгөө шилэн дансны хөтлөлт заавал хийгдэх ёстой. Тэгэхээр асуудлууд чинь бараг 80 хувийг нь ил болгосноор л асуудал өөрөө шийдэгддэг л дээ. Тэгэхээр ил болгоно гэдэг нь аль түрүүн бид нар хуультай шилэн дансаа л маш сайн хөтөлдөг. Тэрний араас хөөцөлдөх л байх ёстой юм байна лээ л дээ. Тэгээд энэ дээр ч гэсэн аудитын дүгнэлт дээр шилэн дансны нэгдсэн энэ цахим хуудсан дээр системүүд нь мэдээллээ солилцох, мэдээлэл нь бүрэн бус хамрах хүрээгээр ангилаагүй, регистрийн дугаараар хүртэл хайлт хийх боломжгүй л байдаг юм байна л даа. Уг нь энийг жосоохон сайжруулчих юм бол энэ мэдээллийг чинь бусад хүмүүс хөндлөнгөөс аваад маш олон дүгнэлтийг гаргаад ирж болдог байхгүй юу. Тэгэхээр ерөөсөө уул нь Монгол Улсын эдийн засаг нэг тийм сүртэй том биш шүү дээ жижигхэн. Тэгээд бид нарын одоо авч байгаа арга хэмжээнүүд ч гэсэн цөөхөн ойлгомжтой байхгүй юу.

Тэгэхээр энийг хамгийн гол нь маш сайн анализ хийхэд тэр дата нь хэрэгтэй. Тэгэхээр тэр шилэн дансаа сайн хөтөлддөг бол тэрэн дээр бүх зүйл нь гарч ирээд илүү асуудлуудыг ойлгомжтой дэлгээд гаргаад

*ирэх боломжтой л юм байгаа юм л даа. Тэгэхээр энэ 2 дээр анхаараасай аудитын зөвлөмж биелүүлэх тэгээд шилэн дансны хөтлөлт 2-ыг л ер нь бид нар шийдчих юм бол магадгүй бид нарын өнөөдрийн ярьж байгаа асуудлыг ер нь өөрөө шийдэгдэх бүрэн боломжтой байхгүй юу.*

*Тэгэхээр энэ дээр цаашидаа анхаарах ёстой болов уу гэж бодож байна. Баярлалаа.*

**Б.Жаргалан:** *Гишүүд үг хэлж дууслаа.*

*Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгдсэн тайлан болон Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргах санал, дүгнэлтийг Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны хуралдаанд Эдийн засгийн байнгын хорооны гишүүдээс нэг хүн унших ёстой*

*байгаа. Манайхнаас унших хүн байна уу? Батнайрамдал гишүүн түрүүлж гараа өргөв үү? Санал дүгнэлтийг Лувсанжамц гишүүн уншиж танилцуулна аа.*

*Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан болон Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулж дууслаа.*

*Эдийн засгийн байнгын хорооны өнөөдрийн хэлэлцэх асуудал үүгээр дуусаж хуралдаан өндөрлөж байна. Хуралдаа идэвхтэй оролцсон гишүүддээ баярлалаа.*

*15.45 цагт*

**ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,  
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ П.МЯДАГМАА**